

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-5</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>6-41</i>
1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	6-38
2.Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай	38-41

***Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Төсвийн байнгын хорооны 08 дугаар сарын 15-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 23 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Мөнхсоёл;

Чөлөөтэй: Д.Батлут, Б.Батцэцэг, Г.Ганбаатар.

***Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны
өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минут хот, Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч Л.Хосбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Л.Эрдэнэбадрах, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч дарга, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Үндэсний Аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Л.Мөнхцацрал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Р.Рэнцэнбаатар, Н.Ууганбаатар, А.Энхбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн газрын Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Сонор, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Санхүү хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн газрын зөвлөх Д.Мөнхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Б.Мөнгөн-Аргамж, мөн хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, ахлах зөвлөх Ш.Батцэнгэл, референт М.Мандхай, С.Тэгшжаргал нар байлцав.

Төсвийн төслийн талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төсөлтэй холбогдуулан гаргасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр нар танилцуулав.

Төсвийн төсөл болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Х.Ганхуяг, Г.Дамдинням, З.Мэндсайхан, Н.Алтанхуяг, Б.Түвшин, Х.Булгантуяа, Д.Пүрэвдаваа, Р.Батболд нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч дарга, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн, Ж.Батжаргал, Б.Түвшин, Д.Пүрэвдаваа, Х.Ганхуяг, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	8
Бүгд:	21
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.	

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т “Ил санал хураалтыг явуулахад техникийн гэмтэл, саатал гарсан зэрэг санал хураалтын систем ажиллахгүй болсон тохиолдолд санал хураалтыг гар өргөж явуулна.” гэж заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх санал хураалтыг техникийн саатал гарсан учир гар өргөж явуулья гэсэн горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	10
Бүгд:	21
52.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.	

Хамт өргөн мэдүүлсэн:

Ц.Даваасүрэн: 1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 11
Бүгд: 21
47.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 10
Бүгд: 21
52.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Ц.Даваасүрэн: 1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 9
Бүгд: 21
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 2.Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 10
Бүгд: 21
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатарыг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Х.Болормаа нар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 9
Бүгд: 21
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

“Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах байсан боловч Байнгын хорооны гишүүд санал хураалтын дүнг маргаантай гэж үзсэнээр уг асуудлыг дараагийн хуралдаанаар шийдвэрлэхээр хойшлуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 24 минут үргэлжилж, 25 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их эзэн
Чингис хаан” танхим 14 цаг 23 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Даваасүрэн: Төсвийн байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амрыг эрье. Байнгын хороонд ирэх ёстой 25 гишүүнээс 15 ирсэн. Ирц 60 хувьтай байгаа учраас. Энийг нь манай техникийнхэн шалгаад нягтлаад өг. Нэг хүн нэмэгдэх ёстой Батболд гишүүний ирцийг оруулаад явъя. 16 ирсэн гэсэн үг. Би ирцийг танилцуулъя. Ирсэн гишүүд. Норовын Алтанхуяг, Телуханы Аубакир, Далайн Батбаяр, Рэнцэндоржийн Батболд, Жигжидийн Батжаргал, Жадамбаагийн Баясгалан, Хөххүүгийн Болормаа, Хүрэлбаатарын Булгантуяа, Пүрэвжавын Ганзориг, Хассуурийн Ганхуяг, миний бие, Гонгорын Дамдинням, Загджавын Мэндсайхан, Даваахүүгийн Пүрэвдаваа, Банзрагчийн Түвшин, Ганзоригийн Тэмүүлэн, Даваагийн Цогтбаатар гэсэн 16 гишүүн ирцэд орсон. Чиний нэр уншигдсан уу сая. Батбаяр уншигдсан уу? Тийм. Ингээд 16 гишүүн оролцож байна. Ирц хангалттай байна аа.

Ингээд хуралдаанаа нээснийг мэдэгдье. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя аа.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх 2 асуудал байна.

Эхний асуудал Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл хэлэлцэх эсэх асуудал. Санал, дүгнэлтээ Их Хуралд оруулна.

Хоёр дахь асуудал Байнгын хорооны тогтоолын төсөл Зарлагын дэд

хорооны даргыг сонгох гэсэн ийм 2 асуудал байна.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга уу? Хэлэлцэх асуудлаа тасалъя.

Эхнийхээ асуудалд оръё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Өрийн өдөрлөгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж хэсье ээ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн энийг би танилцуулъя. Ажлын хэсгийн ажлын хэсгээ оруулчих. Лувсаннямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Равжихын Эрдэнэбүрэн Монгол Улсын сайд, 20 минут хот-Үндэсний хорооны дарга, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн хөгжлийн сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч. Энэ ирээгүйг нь унишлт байна уу? Дэлэгийн Загджав Монголын Ерөнхий аудитор, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Рэнцэнбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын гишүүн, Ядамын Самбууням ирсэн байна уу? Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч дарга, Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд

дарга байна уу? Алга байна. Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний Аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор байна. Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Туулын Хосбаяр НЗД-ын Нийгмийн салбар, ногоон хөгжил, агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч байна уу? Нийслэлээс ер нь байна уу? Нийслэл ер нь ач холбогдол өгч байна уу? Нямдэлэгийн Мандуул НЗД-ын Эдийн засгийн хөгжил дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч байна уу? Энэ нийслэл өөрөө тэгээд яагаад оролцохгүй байна? Доржсүрэнхорлоогийн Саруул ЗГХЭГ-ын Хууль эрх зүйн газрын дарга байна. Лувсандагвын Мөнхцацрал Үндэсний аудитын газрын аудитын менежер, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга байгаа юу? Энэ хөрөнгө оруулалт дээр бас юмнууд яригдана шүү. Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлогын төлөвлөлтийн газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга алга уу? Дугаржавын Амгалан НЗДТГ-ын Хууль тогтоомж, эрх зүйн газрын дарга, Очиржанцангийн Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, алга уу? Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга алга уу? Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга алга. Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга байна.

Солонгын Тулга Сангийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын Хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга байна. Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Дүгэрсүрэнгийн Мөнхбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын зөвлөх, Болдбаатарын Энхжисин НЗД-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лхагвадоржийн Эрдэнэбадрах НЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна. Энэ ирээгүй байгаа зарим улсууд ялангуяа энэ нийслэлийн холбогдох дарга нар бас төрийн байгууллага оролцоно шүү. Төрийн байгуулалт дээр байгаад байгаа юм уу?

Ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг орж ирж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайд 3 номерын микрофон ажлын хэсгийн Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлт болох сонгуулийн холимог тогтолцоогоор анхны 126 төлөөлөл бүхий Улсын Их Хурал 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдөр байгуулагдаж, улс төрийн намуудад ард түмний дэмжлэгийг авсан иргэдийн саналыг гээхгүй байх зарчим дор МАН, АН, ХҮН намын төлөөллөөс бүрдсэн хамтарсан Засгийн газар байгуулагдаж хурдтай, хөгжлийн төлөөх зориг, үнэт зүйлд нэгдэж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлэхээр энэ удаагийн төсвийн тодотголыг та бүх бүхэнд танилцуулж байгаа.

Энэ хүрээнд 3 намын мөрийн хөтөлбөрт туссан нийтлэг зорилтод суурилсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулсан. Ийнхүү бид Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудал, сорилтыг шийдвэрлэх, эдийн засгийн суурийг тэлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг хурдтай, зоригтой, бодитой хэрэгжүүлж эхлэх үндсэн суурийг тавьж байна. Ирэх 4 жилд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 120 орчим их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр шаардлагатай байна. Гэвч улсын төсвийн эх үүсвэр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дөнгөж 12.3 хувийг л санхүүжүүлэх боломжтой юм аа. Тийм ч учраас нэн тэргүүнд хөрөнгө оруулалтын орчноо сайжруулах хувийн хэвилийг дэмжих, эрх зүйн цогц реформыг олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын дараагийн 30 жилийн хөгжлийн шинэ загварт тохирсон дунд, урт хугацаанд төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудыг олон улсын сайн жишигт нийцүүлэн боловсронгуй болгон өргөн барьж байна. Монгол Улс анх Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг уул уурхайн салбарын эрчимтэй өсөлтийн эхэн үе болох 2010 онд баталж эдийн засгийг уул уурхайн мөчлөг дагасан савлагаанаас хамгаалж, төсвийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд 2010 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Тухайн үетэй харьцуулахад өнөөдрийн манай улсын ДНБ-ий хэмжээ 3.7 дахин, төсвийн тэнцвэржүүлсэн орлого 4 дахин, гадаад худалдааны нийт эрэлт 2.3 дахин өсөж эдийн засгийн багтаамж одоо 3 дахин тэлснээс үзвэл Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагууд төсвийн тогтвортой байдлыг хангаж эдийн засгийн өсөлтийг

дэмжихэд түүхэн үүргээ гүйцэтгэснийг харуулж байна.

Монгол Улсын хөгжлийн шинэ үе шатад нийцүүлэн шинэчлэн боловсруулсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд туссан голлох зарчмын өөрчлөлтийг дурдвал 1 дүгээрт нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээг дотоод бүтээгдэхүүний 30 хувиас хэтрүүлэхгүй байлгаж, байнгын шинжтэй тогтмол гардаг төсвийн урсгал зардлыг эдийн засгийн багтаамжийн тодорхой хувиар хязгаарласнаар төсвийн эдийн засаг дахь оролцоог хязгаарлах хөгжлийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийх төсвийн орон зай үүсэх нөхцөл бүрдүүлнэ ээ.

Хоёрдугаарт нэгдсэн төсвийн суурь тэнцлийг ДНБ-ий 2 хувь буюу түүнээс дээш одоо ашигтай байлгаж дотоодын эдийн засгийн нөөц сууриас бүрдсэн тэнцвэржүүлсэн орлогын эх үүсвэрээр төсвийн зардлыг хязгаарлаж, суурь тэнцлийн ашгийг тооцох ба уг эх үүсвэрээр өрийн үндсэн төлбөрүүдийг жил бүр төлөхөд зарцуулна.

Ингэснээр ирээдүйд өрийн дарамтад орох эрсдэлээс одоо бүрэн сэргийлэх боломж бүрдэнэ ээ.

Гуравдугаарт Засгийн газрын өөрийн нэрлэсэн дүнгээр тооцсоноор дэлхий дахинд Засгийн газрын өрийн хязгаарыг мөрддөг 72 улсын 65 улстай ижил аргачлалтай болж эдгээр орнуудын нийтлэг аргачлалд шилжсэнээр харьцуулах боломж нэмэгдэхийн зэрэгцээ иргэд олон нийтэд ойлгомжтой болж хяналт тавихад хялбар болох юм.

Дээрх өөрчлөлтүүдийг Төсвийн тогтвортой байдлын тухай Өрийн удирдлагын тухай хуульд оруулснаар бид шинэ 30 жилийн хөгжлийг эхлүүлэх томоохон төслүүдийг гадаадын зээл тусламж, үнэт цаас, төр хувийн хэвшлийн түншлэл хувийн секторын эх үүсвэрээр хэрэгжүүлж, Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого

бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Шинэ сэргэлтийн бодлогод туссан зорилтуудад хүрнэ ээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн суурь зарлага дээд хэмжээ 27.3 их наяд төгрөг буюу ДНБ-ий 34 хувь, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1.6 их наяд төгрөг буюу ДНБ-ий 2 хувийн одоо ашигтай байж Засгийн газрын өөрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн хэмжээг 47.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 60 хувьтай тэнцэхээр тооцлоо.

Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайдад баярлалаа.

Дараагийн танилцуулгыг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн тогтвортой байдлын дүгнэлтийг Зөвлөлийн дүгнэлтийг Тогтвортой байдлын зөвлөлийн дарга Энхбаяр танилцуулна. Энхбаяр 6 номерын микрофоныг өгье.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт. Төсвийн хүрээний мэдэгдэл. Дагасан хуулиуд дээр хийсэн. 6 номерыг өгье 5-ыг өгчихье. Энхбаяр.

Н.Энхбаяр: Эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өнгөрсөн онд орсон өөрчлөлтийн дагуу энэ оны 1 дүгээр сард Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 7 гишүүн орон тооны гишүүн болгож томилогдсон. Үүнээс хойш ингээд 6, 7 дахь сардаа үйл ажиллагаа явуулж байна. Улсын Их Хурлын гишүүд шинээр томилогдсонтой холбогдуулаад өнгөрсөн хавар бид нөгөө хүргүүлж байсан тайлангаа та бүхэнд бас дурдахыг хүсэж байна.

Хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу өнгөрсөн оны 3 дугаар сард Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай ирэх 3 жилийн макро эдийн засгийн төсөөллийг боловсруулаад энэ саналаа Засгийн газарт хүргүүлсэн байгаа.

Төсвийн байнгын хороонд энэ санал судалгаан дотор дурдагдсан гол зүйл бол бид Монгол Улсын эдийн засгийн одоо өнөөгийн нөхцөл байдал, төсөвт тулгарч байгаа эрсдэлийг дурдсан байгаа. Тэгэхээр энэ нэгэнт та бүхэнд Их Хурлын гишүүд өмнө нь хүргэгдсэн учраас энэ байр суурь бидний байр суурь одоо төсвийн эрсдэл хэвээрээ байна гэж бид үзэж байгаа.

Монгол Улсын гадаад зах зээл, экспорт, түүхий эдийн хамааралт байдал өндөр байгаа. Төсвийн зарлага бол тэлж байна гэдгийг тухайн үед ч гэсэн манай олон судлаачид хэлж байгаа.

Засгийн газраас өргөн өргөн баригдаад байгаа төсвийн тодотгол, төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдуулаад бид өчигдөр нэг өдрийн дотор одоо энэ саналаа бэлтгэсэн байгаа богино хугацаанд. Өргөн баригдаж байгаа томоохон зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлага тулгамдаж байгааг бид ойлгож байна. Гагцхүү өргөн баригдаж байгаа энэ санал дотор тусгагдаж

байгаа төсвийн зарчмыг өөрчлөх гэдэг саналтай бид бас төдийлөн санал нийлэхгүй байгаа. Энэ дотор ямар өөрчлөлт гарах вэ гэхлээр төсвийн тэнцэл дээрээс хөрөнгө оруулалтын зардлыг хасаад урсгал зардал дээрээ одоо төсвийн тэнцлээ тооцдог болъё гэсэн ийм санал байгаа.

Тэгэхээр энэ тал дээрээ бид бэлэн үү гэдгээ бид нар 1 дүгээрт маш сайн бодох ёстой. Гол нь энэ хөрөнгө оруулалтын зардлыг бид нар тусгайлан ингээд гаргахлаар хөрөнгө оруулалтын зардлаа бид нар хянах бололцоотой юу гэдэг хөрөнгө оруулалтын зардлаа бид нар цаашидаа хянах бололцоотой юу гэдэг асуудал гарч ирж байгаа. Бусад улсуудын одоо ярьдгаар нөгөө сайн жишгээ харах юм бол Улсын хөрөнгө оруулалтын тухай хууль байгаа. Хуулиар зохицуулсан байгаа. Одоогоор манайд улсын хөрөнгө оруулалтыг зөвхөн Төсвийн тухай хуулийн 27.1 дүгээр заалт дээр улсын хөрөнгө оруулалт ямар шаардлага тавигдах вэ гэсэн ийм л нэг бүлэг заалт байгаа. Тэгэхээр цаашидаа бид хөрөнгө оруулалтыг хэрхэн төлүүлэх вэ, хэрхэн хяналт тавих вэ гээд энэ зохицуулалтыг маш сайн болгохгүй бол улсын хөрөнгө оруулалтын зардал маань үндсэндээ ингээд цаашидаа хязгаарлах зүйлгүй болох ийм эрсдэл байгаа. Энэ бол төсвийн эрсдэлийг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл байна гэж үзэж байгаа юм.

Хоёрдугаарт санал болгож байгаа улс орнуудын жишгээр Их Британи улсын жишгээг авсан байгаа. Тэгэхдээ энэ дээр бас бид нар нөгөө ялгаатай байдал байгаа гэдгээ бид нар бас сайн ойлгох хэрэгтэй. Их Британи улс бол энэ хөрөнгө оруулалтын зардлаа хасаж тооцож байгаа цөөн улсын нэг. Гэхдээ өндөр хөгжилтэй орнууд бол нягтлан бодох бүртгэл нь бүрэн акрил суурьтай байгаа. Хөрөнгө оруулалтын зардлыг тооцдог аргачлал өөр байгаа гэдгийг бид нар ойлгох ёстой. Өндөр хөгжилтэй орнуудад нийт хөрөнгө оруулалт, цэвэр хөрөнгө оруулалт гэсэн ийм 2 ялгаатай ойлголт байгаа. Нет инвестмент гэдэг ойлголт.

Манай хувьд бол ийм ялгаатай ойлголт байхгүй. Одоо бид бохир буюу тухайн жилийн хөрөнгө оруулалтаа л тусгаад явж байгаа учраас энэ хооронд ялгаа их бий. Манайх нөгөө улсын салбартаа бүрэн шилжээгүй ээ. Тэгэхээр бид үндсэндээ энэ шинэ зарчим руу шилжихэд энэ хэд хэдэн талаасаа бэлэн бус байна гэж бид үзэж байгаа юм.

Тэгэхээр бид бол энэ төсвийн хүрээний мэдэгдэл нь энэ аргачлал тооцдог аргачлалыг үндсэндээ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хэвээр үлдээх ёстой гэсэн саналыг хэлж байгаа. Гадаад өрийг тооцохдоо нэгдсэн үнээр тооцдог болох гэсэн өөрчлөлтийг бид дэмжиж байгаа. Энэ тал дээр өөр санал байхгүй. Аливаа энэ томоохон төслүүдийг хэрэгжүүлэхдээ бид нар бас нэг бодох ёстой юм бол УИХ-аас 2020 онд баталсан Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль байгаа. Энэ дээр Монгол Улсын урт дунд хугацааны хөгжлийн бодлого гэж юу вэ гээд маш тодорхой заачихсан байгаа. 2020 онд баталсан алсын хараа мөн 5 жилийн үндсэн чиглэл, үндсэн чиглэлийн хавсралтаар батлагдсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр дотор томоохон төслүүдэд шаардагдах хөрөнгө оруулалтын зардлыг тодорхой тусгаад ингэчихсэн ингээд явж байгаа.

Тэгэхээр эхлээд тэр хөгжлийн бодлогын бичиг баримтаа бид нар нөгөө уялдаатай байлгах гэсэн зорилтоо хангахын тулд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт бодлогоо дунд хугацааны бодлогын бичиг баримт дээр хэрхэн нийцтэй байгаа вэ гэдгийг бид нар анхаарах ёстой гэсэн саналыг хэлж байгаа юм. Үүнийхээ дараа нөгөө шаардагдах хөрөнгө оруулалтын нөгөө ач холбогдол маань дараалал маань яг юунд чиглэгдэх ёстой вэ гэдэгт ач холбогдлын дарааллаа тогтоох ёстой. Түрүүний бидний дурдаад байгаа нөгөө сайн улс орны жишгээ улсын хөрөнгө оруулалттай Засгийн газрын түвшний, салбарын түвшний, орон нутгийн түвшний гээд

нөгөө хөрөнгө оруулалтаа 3 ангилчхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр ингээд ангилаад ирэхээр нөгөө түрүүн эхний ээлжид санхүүжүүлэх ёстой маш чухал ач холбогдолтой гэдэг нөгөө стратегийн ач холбогдолтой гэдэг хөрөнгө оруулалт нь илт тодорхой болгоод ялгараад ирж байгаа юм. Тэгэхээр ийм байдлаар бид нар нөгөө эрх зүйн бодлогын орчноо хараахан шинэчлээгүй байгаа учраас маш олон хөрөнгө оруулалтын төслүүд эрэмбэ нь ойлгогдохгүй ингээж орж ирэх эрсдэл байгаа юм гэдгийг л энэ дээр анхааруулахыг хүсэж байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Чи нөгөө бүртгэлийнхээ юмыг танилцуулсан уу? Ингээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөлөл эдгээр хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Сангийн сайдын танилцуулга Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг танилцууллаа.

Танилцуулга, дүгнэлттэй холбогдуулаад асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Кнопоо дарах байх тийм ээ? Батбаяр орох гэж байна уу тэ? Батбаяр, Батболд болчихсон уу? Тэмүүлэн, Ганхуяг, Дамдинням, Мэндсайхан, Алтанхуяг, Түвшин, Булгантуяа, Пүрэвдаваа, Батболд, Батбаяр. Ингээд энэ 10 гишүүнээр тасаллаа. Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

Г.Тэмүүлэн: Би нэг 2 гуравхан суурь асуудлыг л хөндөж тавих гээд байгаа юм. Зарчмын хувьд би Засгийн газраас оруулж ирж байгаа төсвийн тодотгол дагалдуулж 14, 15 хуульд оруулж байгаа. Энэ асуудлууд дээр бол хувь хүнийхээ үүднээс нөгөө талдаа өнгөрсөн жил төсвийн суурь энэ шинэчлэлийн реформын баримт бичгүүдийг бас өөрөө өргөн барьж өмнөх парламентын 35 гаруй гишүүдтэй хамтдаа өргөн барьж энэ төсвийн

сахилга бат болоод хариуцлагыг сайжруулах үүднээс бол энэ шинэчлэлийг эхлүүлсэн хүнийхээ хувьд.

Ц.Даваасүрэн: Микрофоноо их ойрхон ярихгүй бол сонсогдохгүй байгаад байна уу тэ? Энэ чангаруулагч нь өөр дээрээ байна уу аль эсвэл цаанаасаа чангаруулж байна уу? Манай техникийнхэн.

Тэмүүлэн гишүүний микрофоныг чангалъя. Цагийг нь зогсоосон уу? Минийх арай хэтэрхий чанга болчихлоо.

Г.Тэмүүлэн: Одоо арай дээр байна уу? Би энэ Засгийн газраас орж ирж байгаа төсвийн тодотгол дагалдуулж оруулж ирж байгаа Төсвийн хуулийн өөрчлөлтүүд, төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн өөрчлөлттэй холбоотой асуудлуудаар бол зарчмын хатуу байр суурьтай байгаа. Өчигдөр би бүлгийн хурал дээр энэ байр сууриа бас хэлье тодруулж асууж лавлая гэсэн байр суурьтай байсан. Үнэндээ бид нар бас нэг уг нь өнгөрсөн жил өмнөх парламент 35 гишүүд нэгдэж нийлж байгаад нэг өнгөрсөн магадгүй Монгол Улсын хамгийн том алдаа бол 20, 30 жилийн энэ төсвийн сахилга бат, хариуцлагагүй байдал.

Дээрээс нь одоо юу гэдэг юм ил тод бус энэ асуудлууд дээр ер нь жоохон нэг өөрчлөлт хийж олон нийтэд нээлттэй эргээгээд одоо юу гэдэг юм улс орноо бас нэг ирээдүйн эрсдэлд оруулахгүй байх энэ асуудлууд дээр бол суурь өөрчлөлт хийе л гэж уг нь өөрчлөлт оруулсан. Би тэгээд дагаж орж ирж байгаа хуулиудтай холбоотойгоор Төсвийн тогтвортой байдлын хуулийн өөрчлөлт болоод Төсвийн тухай хуулийн өөрчлөлтүүдийг бол дэмжихгүй ээ. Зарчмын хувьд бүх өөрчлөлтүүдийг. Эргээд энэ нэгдсэн төсвийн суурь зарлага гэх юм бол энэ одоо шинэ ойлголтын Төсвийн тогтвортой байдлын хуулийн тухай хуулиар оруулж ирж байгаа чинь зарчмын хувьд маш буруу асуудал, маш буруу асуудал. Бараг олон улсад байхгүй шахуу энэ асуудлыг оруулж ирээд энэ суурь тэнцэл гээд

энийгээ тооцохдоо эргээд энэ үнэт цаас ч гэдэг юм уу гадаад зээлээр санхүүжүүлж байгаа зардлаа оруулахгүй гэдэг юм уу түүгээр оруулж ирж байгаа хөрөнгө оруулалтаа оруулахгүй гэдэг асуудлууд чинь өөрөө маш том эрсдэлийг дагуулах гэж байгаа маш том эрсдэлийг дагуулна. Тэгээд цаашидаа яах юм? Тэгээд төсвийн хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэнэ. Сахилга бат байхгүй болно, төрийн оролцоо нэмэгдэнэ, хувийн хэвшлийн оролцоо хумигдана. Төсвийн тогтвортой байдал өөрөө байхгүй болно. Ийм ийм том эрсдэлүүдийг бид нар бий болгочхоод цаашидаа одоо яах юм бэ? Төсвийн тогтвортой байдлын хууль бараг цаашидаа байх шаардлага байгаа юм уу, үгүй юм уу гэдэг асуудал болох гээд байна шүү дээ.

Бид нарын чинь хамгийн том асуудал уг нь бол энэ төсвийг бид нар нэг төсвийн орлого бүрдүүлдэг хэрэгсэл биш эдийн засгийг хөшүүргэддэг, хувийн хэвшилээ дэмждэг, төр нь өөрөө хариуцлагатай байдаг, сахилга баттай байдаг. Зөв зүйлдээ эрх ашгийн эрэмбийн хүрээнд хөрөнгө оруулалт хийдэг ч гэдэг юм уу ийм л шинэчлэлийг л бид нар хийнэ гэж уг нь өнгөрсөн жил энийг нь өргөн барьж батлуулаад дөнгөж одоо юу гэдэг юм энэ жилээс хэрэгжиж эхэлж байна.

Анхныхаа төсвийг бид нар оруулж ирэх гэж байна. Гэтэл эргээд төсвийнх нь алдагдал болоод гадаад өр зээлийнх нь хэмжээ нь өөрөө энэ төсвийн суурь зардал, суурь зарлага хэмээх энэ ойлголтод багтахгүйгээр ингээж явбал цаашидаа яах юм бэ? Энэ төсөв санхүүгийн салбар энэ аюулгүй байдлын асуудлууд чинь яах юм? Төлбөрийн тэнцлийн хямрал үүсвэл яах вэ? Үүнийгээ дагаад валютын ханшийн хямрал үүсвэл яах вэ? Өр зээлийн хямрал үүсвэл яах вэ? Төсвийн тэлэлтийн энэ зардал болгон чинь өөрсдөө цаашидаа инфляц болж өсөх гээд байна аа. Төлбөрийн тэнцэл болж төлбөрийн тэнцэл дээр бүүр сөргөөр нөлөөлөөд байна. Гадаад валютынхаа албан нөөц дээр сөргөөр нөлөөлөөд байна гэдэг асуудлыг зөндөө ярьсан шүү дээ.

Гэтэл яг үүнийхээ эсрэгээр юм оруулаад ир гэх юм.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайд хариулъя. 3 номерын микрофон өгье.

Б.Жавхлан: Тэмүүлэн гишүүний асуулт, саналд хариу хариулт өгье. Төсвийн шинэчлэл гэдэг асуудал маань өөрөө энэ их ерөнхий ойлголт байдаг аа. Нэг удаа хийгддэг асуудал биш үеийн үед л хийгддэг. Үеийн үед Улсын Их Хурал, үеийн үеийн л одоо Сангийн сайдын хүсээж хийгддэг асуудлууд энэ төсвийн шинэчлэл реформын асуудлууд байдаг. Оновчтой болсон зүйлүүд ч байна, оновчгүй үр дүнгүй болсон зүйлүүд ч байдаг. Өнгөрсөн жил хийгдсэн Төсвийн тухай хууль болон одоо бусад өөрчлөлтүүдийн одоо яг амьдрал дээр хэрэгжих хугацаа ингээд эхэлж байгаа нь бол одоо яг үнэн. Улсын Их Хурал одоо шинэ Улсын Их Хурал, шинэ парламент, шинэ Засгийн газар, тэр дундаа хамтарсан Засгийн газар. Энэ цаг үеийг бид нар том масштаб дээр харах юм бол энэ цоо шинэ тоолол эхэлж байгаа шүү. Бид өнгөрсөн зуныг харах юм бол 1990 он томоохон одоо нийгмийн энэ өөрчлөлтүүд, тэрнээс хойш ер нь Ковид хүртэл ковидоос хойш гэдэг цоо шинэ одоо дэлхий дахинд ийм тоолол эхэлж байгаа.

Дараагийн шинэ 30 жилийг бид одоо энэ боломж, энэ хөгжил, эдийн засаг, нийгмийн энэ одоо бодит боломжуудыг бид хөгжил болгох ийм онцгой шаардлага цаг үе бидний өмнө тулгарч ирж байгаа. Төсөв гэдэг бол өөрөө 2 зорилготой.

Нэгдүгээрт төрийн үйл ажиллагааг одоо тасралтгүй байх зардлаар ингээж хангаж гүйцэтгэлийг нь хангах ийм үүрэгтэй нэг талаар, нөгөө талаар эдийн засгийнхаа өсөлтийг дэмжих ийм үндсэн 2 үүрэгтэй байгаа. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд төсөв маань нэлээдгүй бас сорилт дундуур явж ирсэн.

Эхний 2 жил одоо дэлхий нийтээрээ айхтар бид нар ковид эдийн засгийн уналтын дунд одоо бид маш хүнд цаг хугацаа дууссан. Сүүлийн 2 жил нь гадна талдаа бас нэлээн одоо геополитикийн олон асуудалтай хэдийгээр хил нээгдсэн боловч энэ дайн гэдэг том геополитикийн хаалт доор, дээвэр доор бас л хүндхэн л явж байна. Гэсэн хэдий ч ямар ч байсан энэ 4 жил одоо бид төсвийн тусгай шаардлагуудаа одоо хуулиар батлагдсан тэр хүрээнд ягшигтал биелүүлж төсвийн сахилга батыг одоо ялангуяа гадна талдаа олон улсын санхүүгийн байгууллагуудын өмнө хүлээсэн өр зээллэгийн хувьд маш хариуцлагатай явж ирсэн. УИХ-аас батлагдсан дунд хугацааны өрийн стратегиа маш сайн одоо сахиж ирсэн. Энэний үр дүнд одоо өрийн хязгаар маань одоо гүйцэтгэл 40-өөс доош 39 хувьтай болж ирж байгаа.

Мөн одоо бусад төсөвтэй холбоотой төсөв дагасан макро тоонууд ч байна одоо сүүлийн 2 жил ялангуяа одоо улам их сайжирч бидэнд эдийн засгийн тогтвортой одоо өсөлтийг бий болгох ийм боломж дээр төсвийн бодлого явж ирсэн. Ийм байгаа.

Тийм учраас одоо бид цаашидаа улс орныхоо хөгжлийг арай өөрөөр одоо арга өнцгөө бид нар тэлж харах шаардлага одоо энэ удаагийн.

Ц.Даваасүрэн: Нэг минут нэмээд өгчихье. Жавхлан сайд дээр.

Б.Жавхлан: Тийм учраас бид энэ одоо эдийн засгийн өсөлтийг бид төсвийн бодлогоороо дэмжих шаардлагатай болж ирж байгаа юм. Түрүүн Энхбаяр дарга тэр хөрөнгө оруулалтыг тусад нь тооцно гээд нэршил дээрээ арай жоохон өөрөөр хэлчихье. Хөрөнгө, төсвийн хөрөнгө оруулалтынхаа тэнцэл дотроо байдгаараа байна. Харин гадаад зээл тусламжаар одоо санхүүжилтийн зардал нь наадах чинь бид одоо аргачлалаар хязгаар тооцохдоо арай өөрөөр тооцдог больё гэж байгаа байхгүй юу. Суурь

зардал буюу тогтмол орж ирдэг орлого, тэнцвэржүүлсэн орлогоороо тогтмол шинжтэй одоо байнга гардаг суурь зардлуудаа одоо хангадаг. Энэ тэнцлийг бид нар суурь тэнцэл гэж байгаа юм. Тэрэн дотор чинь төсвийн хөрөнгө оруулалт бүгд ороод явна. Бүртгэлийн хувьд энд ямар ч өөрчлөлт гарахгүй. Гагцхүү бид төсвийн хязгаараа тооцох аргачлал дээрээ гадаад зээл тусламжаар санхүүжих томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг одоо суурь тэнцлээс нь тусад нь харж, дунд хугацааны одоо өрийн.

Ц.Даваасүрэн: Дараагийн хүний асуултад хариулахдаа нэмээд явъя. Тодруулъя. Тэмүүлэн гишүүн тодруулъя.

Г.Тэмүүлэн: Яах вэ би одоо материал нь ч дөнгөж нэг хоногийн өмнө орж ирээд л дутуу үзээд л явж байна. Тэгэхдээ үндсэндээ энэ бол энэ яг төсөв дагасан хуулиудтай холбоотойгоор Төсвийн тогтвортой байдлын хуультай холбоотойгоор магадгүй энэ 10 онд батлагдсан хууль сүүлийн 14 жилийн хугацаанд мөрдөгдөх хугацаандаа хийгдэж байгаа хамгийн том ухралт болох гээд байгаа юм. Хамгийн том алдаа болох гээд байгаа юм. Бид нар ийм зүйлийг хийж болохгүй шүү дээ. Уг нь урагшаагаа ахиад биш энэ нэг эрсдэлээс нь хамгаалдаг байя гэж байтал одоо Сангийн яамны энэ оруулж ирж байгаа би магадгүй та нарын алдаа гэж хэлэх гэж байгаа юм шүү. Та нарын оруулж ирж байгаа энэ хуулийн өөрчлөлтүүд чинь. Энд алдааг чинь Монгол Улс даяараа ирээдүйд Монголын ард түмэн үүрэх л ийм алдаа болох гээд байна. Ийм өөрчлөлтийг бид нар хийж болохгүй. Зарчмын хувьд. Суурь зарлага, суурь тэнцэл гэх ийм одоо шинэ нэр томъёо оруулж ирээд үүгээрээ дамжуулж өр зээл алдагдлаа нэмэгдүүлдэг ийм одоо юу гэдэг юм дураараа хэмжээгээ өөрчлөх ийм асуудал байж болохгүй шүү дээ. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энэ дээр юу гэж үзэж байгаа юм.

Ц.Даваасүрэн: 3 номерын микрофоныг өгье. Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Энэ одоо төсвийн энэ дүрмийг улс орон болгон өөр өөрсдийнхөө одоо эдийн засгийн хүч чадал, энэ боломжид тулгуурлаж маневрлаж одоо тухайн үеийнхээ нөхцөл байдалтай уялдуулж өөрчилж ирдэг. Ийм одоо сайн туршилагууд ч их байна. Одоо яг ковидын дараах ялангуяа том эдийн засгууд Америк, Англи, Япон бүгд энэ дүрэм рүүгээ шилжсэн байдаг. Гадаадын тусламжаар санхүүжих томоохон бүтээн байгуулалт одоо энэ эдийн засгийн уналтаас гарах энэ үедээ энэ одоо аргачлалуудыг хэрэглэж, суурь зардал, яг гол тэнцлээ одоо ашигтай гаргаж тэр эх үүсвэр боломжоороо өр зээлийгээ одоо төлж явж ирдэг энэ боломжууд одоо олон улсад байдаг практик шүү.

Энэ цоо шинэ зүйл ч биш. Өмнө нь ч яригдаж байсан. Энэ одоо бид нар энэ яригдаж одоо бид нарын хэрэглэж байгаа төсвийн дүрэм маань 2013 онд батлагдсан хуульчилсан. Тэрнээс өмнө одоо бид нарын энэ ярьж байгаа энэ одоо дүрмээр явж ирсэн байдаг.

Ц.Даваасүрэн: Яах юм дутуу хариулсан гэвэл тодруулж болно. Энхбаяр нэмэлт тайлбар өгөх юм уу? Тэр нөгөө зөвхөн урсгал зардлаар гээд байгаа хөрөнгө оруулалтыг тооцож байгаа гээд байгаад нь хариулт өгчих. Тэгээд дүгнэлт дээрээ та нар бас нөгөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт гаптай зөрчилдөж байгаа талаар бас оруулсан байсныгаа нэг тайлбарлачихмаар байх юм. Яагаад гэвэл наадах чинь бас бүртгэлийн хувьд ОУВС энэ улс орнуудын төсвийн үзүүлэлтийг гаргаж байгаа үзүүлэлттэй жоохон зөрчилдөхөөр л юм байна лээ дээ. Эргэн төлөгдөх цэвэр зээлийн дүн байгаад байгаа юм шиг мөртөө энэ суурь юугаар чинь байхгүй юм шиг харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр 2 баланс байгаа юм шиг харагдаад байгаа учраас энэ дээр нэг тайлбар өгөөдөхье.

Энхбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн юм байна. Хариулъя 6 номерын микрофон.

Э.Ууганбаатар: Гишүүдийн энэ өдрийн амрыг эрье.

I дүгээрт тэр нягтлан бодох бүртгэлийн стандарт болон Төсвийн хуулийн үзэл баримтлалтай нэлээн зөрчсөн ийм нэмэлт, өөрчлөлт орж ирж байгаа. Энд юу гэж байна вэ гэхээр төсвийн суурь зардал, нэгдсэн төсвийн суурь зардал гэдэг шинэ ойлголтыг нэмэлтээр оруулж ирж байгаа. Суурь зардлын тодорхойлолт нь болохоор үндсэндээ нийт зардлаас саяын Жавхлан сайдын хэлснээр гаднын хөрөнгө бонд болон одоо зээлээр санхүүжсэн энэ хэсгийг нь хасаад үлдсэн хэсгийг нь суурь зардал хийнэ гэж хэлж байгаа юм. Бусад нягтлан бодох бүртгэлийн үндсэн одоо зарчмууд болон төсвийнхөө хуулийн үндсэн агуулгыг харах юм бол тэрэн дээр төсвийн орлогыг бол эх үүсвэрээр нь татварын орлого зээлийн орлого гээд эх үүсвэрээр нь, зарлагыг болохоор зориулалтаар нь ангилсан байдаг. Зориулалтаар нь тодорхойлсон байдаг.

Гэтэл энэ нь юу гэж байна вэ гэхээр нэг зардал.

Ц.Даваасүрэн: Нэг минут нэмээд өгчихье. 6 номерт.

Э.Ууганбаатар: Тэрний зарлага шинэ зарлагын категори, зарлага нэртэй категори орж ирж байгаа боловч тэр нь яг орлого шиг эх үүсвэрээр тодорхойлогдсон ийм тодорхойлогч зарлага орж ирж байгаа. Тэгэхээр үндсэндээ тэр зарлагад юуг оруулах вэ гэхээр зээл болон одоо зээлээр санхүүжсэн юм болгоныг тэр төрлийн зарлага руу оруулах бөгөөд дараагийн зүйл нь юу гэж байна вэ гэхээр тэр төрлийн зарлагыг бол үндсэндээ одоо төсвийн шаардлагуудын гадна орхигдуулах ийм өөрчлөлт орж ирж байгаа учраас бид бол энэ одоо юуг өөрчлөлтийг төсвийн тогтвортой байдал болон Монгол Улсыг

төсвийн эрсдэл рүү дагуулах ийм юутай өндөр эрсдэлтэй гэж дүгнэсэн байгаа.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайд 3 номерын микрофон.

Б.Жавхлан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн маань хугацаа бага байсан юм байлгүй дээ. Энд нэг ойлголтын зөрүү байна. Бүртгэлийн хувьд энд ямар ч өөрчлөлт орохгүй. Төсвийн тусгай шаардлагад тооцох аргачлал дээр одоо шинэ нэр томъёо оруулж ирж байгаа болохоос биш нягтлан бодох бүртгэлийн хувьд яг хуучин тэнцлээрээ л явна.

Ц.Даваасүрэн: Харин тийм учраас наана чинь 2 тэнцэл болчихоод байгаа юм биш үү? Нөгөө төсвийн хуучин үзүүлэлтийн тэнцэл нь хэвээрээ эх үүсвэр талдаа зээлүүд нь байгаа эргэж төлөгдөх цэвэр зээл дундаа нөгөө төлөгдөх үндсэн төлбөр нь байгаа мөн ашиглалт нь байгаа. Гэтэл та нар нөгөө нэг төсвийн хүрээний мэдэгдлийн баланс дээрээ аваачаад ийм томъёолол гаргаж ирчхээд байгаа юм биш үү? Сайдын микрофон.

Б.Жавхлан: Тийм төсвийн хүрээнд дээр ингэж орж ирж байгаа шүү дээ. Нийт тэнцэл бол одоо жишээ нь 2.8 хувийн одоо алдагдал дотор байх ёстой гэдэг энэ тоо хэвээрээ. Харин суурь тэнцлийг нэмэх 2 хувиас доошгүй байх ёстой гэдэг илүү их харин чангалсан ийм заалт нэмж орж ирж байгаа юм. Энэ бол тэр одоо суурь тэнцлийг байнга одоо нэмэх байлгах тэр эх үүсвэрээр гадаад зээлүүдээ эргэж төлж байх ёстой. Энэ шаардлагуудыг нэмж одоо төсвийн энэ одоо зээл өрийн харьцааг нь илүү их өндөр шаардлагатай, илүү их дэгтэй явах ийм зохицуулалт орж ирж байна гэж ойлгох хэрэгтэй.

Ц.Даваасүрэн: Тэмүүлэн гишүүн тодруулъя.

Г.Тэмүүлэн: Би зүгээр ойлгоод байна. Магадгүй Засгийн газар хамтарсан Засгийн газар ирэх 4 жилийн хугацаанд их

юм хийх гээд бүтээн байгуулалт хийх гээд хөгжлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн санхүүжилтүүд хэрэгтэй байгаа нь ойлгомжтой. Гэхдээ энийг чинь төсөвтөө эрсдэл учруулахгүйгээр иийдэж болох арга замууд зөндөө байгаа шүү дээ. Тэгээд тэр арга механизмыг судлахгүйгээр одоо мөрдөгдөж байгаа төсвийн тогтвортой байдлын бид бүхний хувьд төсөв санхүү дотроо Үндсэн хууль шиг мөрддөг энэ хуулийг та нар хуулийг нь өөрчилж орж ирж өөрсдийнхөө төсвийн алдагдлыг нэмэгдүүлдэг, өр зээлийг нэмэгдүүлдэг, улс орноо ирээдүйд эрсдэлд оруулдаг энэ хувилбарыг сонгож яах гээд байгаа юм бэ?

Энэ улс орон чинь цаашид дийлэхгүй шүү дээ. Энийг чинь энэ хууль чинь тэгж болохгүй байхгүй юу. Зарчмын хувьд Сангийн яам яагаад одоо мэргэжлийн байгууллага байж өчнөөн жил энэ хуулиа мөрдөж байх ёстой байгууллага байж Үндсэн хууль шиг мөрдөх хуулиа яагаад өөрчлөх гэж орж ирээд байгаа юм бэ? Байгаа хуульд нь нийцүүлж яагаад энэ төсвийнхөө тодотголыг хийж болохгүй байгаад байгаа юм бэ?

Ц.Даваасүрэн: Жавхлан сайдын микрофоныг өгье 3.

Б.Жавхлан: Тэмүүлэн гишүүн оруулж ирсэн төслүүдийг яг бүтнээр нь сайн нэг хараарай. Улам ч их сайжирч орж ирж байгаа шүү. Суурь тэнцэл гэдэг ойлголтыг оруулж ирж тэр нь нэмэх 2 хувьтай байх ёстой үргэлж жил бүр. Ингэж эх үүсвэрийг тусгаарлаж гадаад өр зээлээ энэ хэмжээгээр төлөөд явах үндсэн үрүүдээ ийм өөрчлөлтүүдийг нэмж оруулж ирж байгаа нь харин ч төсвийн тогтвортой байдал цаашидаа одоо энэ төсөв дээр учрах эрсдэлүүдийг гадаад зээл энэ тусламжийн зардлаас нь харин одоо эрсдэлийг нь бууруулсан ийм үзүүлэлт орж ирж байгаа.

Дахиад хэлье бүртгэлийн хувьд ямар ч өөрчлөлт орохгүй зөвхөн одоо хязгаар тооцох энэ аргачлал дээрээ одоо

өөрчлөлт орж ирж байгаа ийм л суурь ойлголт байгаа.

Ц.Даваасүрэн: Энийг тэгээд хэдүүлээ ажлын хэсгийн хүрээнд бас Тэмүүлэн гишүүн оролцоод тэгээд яая. Энэ нөгөө 2014 онд гадаад зээлд төмөр зам, эрчим хүчийг тооцохгүй явна гэдэгтэй ижилхэн л ийм юм болчих гээд байгаа юм байна лээ. Тэрийг хэдүүлээ жоохон анхаарахгүй бол. Ганхуяг гишүүн асуултаа асууя. Энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Х.Ганхуяг: Саяын суурь зарчим тооцооллын суурь зарчмыг нэг их оролдоод хэрэггүй болов уу л гэж бодогдож байна. Гэхдээ яах вэ ажлын хэсэг дээр ярилцаад үзье. Жавхлан сайдын бас энэ төслийг яалт ч үгүй бүгдийг нь уншиж амжихгүй байна. Яг хурал эхэлсний дараа сая аудитын дүгнэлт орж ирж л байна л даа бүүр ингээд хурал эхлээд асуулт хариулт явж байх үед ингээд. Тэгэхээр энэ хурлын өмнө энэ материалуудаа яг бүгдийг нь хүлээлгэж өгдөг баймаар байна. Энэ чинь одоо хурлын дундуур нь материалтай танилцалтай байна шүү дээ тиймээ.

Хоёрдугаарт энэ төсвийн зардалтай холбоотой асуудал дээр асуулт байна л даа. Энэ 2024, 2025, 2026 гээд нэлээн зарлагыг тэлсэн байдалтай л орж ирээд байна. Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр бол төрийн албан хаагчийн тоог бол 10 хувиар багасгана. Цаашидаа ингээд цомхон одоо төрийн албатай болно гэсэн ийм мөрийн хөтөлбөр өргөн баригдсан. Тэгээд зөрөөд орж ирж байгаа нь болохоор урсгал зардал нь зөвхөн энэ оных шүү. Би одоо хөрөнгийн зардлыг ярихаа больё. Одоо тэр хөрөнгө оруулалттай холбоотой асуудлууд бид нар бас Засгийн газрын мөрийн хөтөлбөрүүдийг одоо ярилцаж байх шатад бас ярилцах болов уу гэж бодож байна. Зөвхөн урсгал зардлаа 1.2 их наядаар нэмчхэж байгаа байхгүй юу. Зөвхөн 2024 онд. Тэгээд одоо бид нар чинь одоо ингээд улам л ингээд том том засагтай олон төрийн албан хаагчтай

ийм л юм бий болгох гээд байна л даа. Тэгээд саяын тэр тооцооллын аргаар одоо магадгүй энэ зээлээ хуулиа нэмж авах гээд байгаа юм уу? Ойлгомжгүй байдал бий болоод байна.

Тэгэхээр энэ 2025, 2026 оны төсвийн хүрээний мэдэгдлээ ер нь хэрхэн яаж төсөөлж байгаа юм. Эдийн засаг ер нь ямар байна гэж төсөөлж байгаа юм. Ямар орлого олно гэж төсөөлж байгаа юм. Ер нь энэ тал дээр бас нэг хариу авчихмаар байна. Тэгээд энэ төсөв дагасан хуулиуд дээр энэ одоо бид нарт гарт хүргэгдсэн хуулиуд дээр алга байна л даа. Бас нэг юу харсан юм. Нөгөө төрийн худалдан авахтай холбоотой нэг хуулиуд дээр харж байхад ноцтой байж болзошгүй 2, 3 асуудал харагдана лээ. Одоо тендер зарлаад л 1, 2 удаа зарлаад л шалгуулж чадахгүй шууд ТӨК-аар гүйцэтгүүлнэ гээд. Тэгээд бид нар чинь одоо төр нь аль болох бизнесийн үйл ажиллагаанд оролцохгүй гээд яриад байдаг. Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр тэгээд тусгаад байдаг. Тэгснээ хуулиа оруулж ирэхдээ одоо ингээд тендер шалгаруулаад эзэн олдохгүй бол одоо ингээд шууд ТӨК-аар гүйцэтгүүлнэ гэсэн ийм хууль оруулж ирээд байгаа байхгүй юу. Одоо энэ чинь байж болзошгүй асуудал шүү дээ. Бид нар одоо аль болох хувийн хэвшилээ дэмжье л гээд байдаг. Хууль эрх зүйн орчныг нь дэмжье л гээд байдаг. Хамгийн том ажил олгогч нь одоо төр болчихоод байна.

Хамгийн олон одоо тэр тендер ажлыг өгдөг нь төр болчихоод байна. Тэгээд тэрийг нь одоо ингээд хувийн хэвшил нь аваад явчихаараа бас яагаад юунд нь болохгүй байгаад байгаа юм бэ? Энэ дээр нэг хариулт авчхаад дахиад тодруулъя аа.

Ц.Даваасүрэн: Хариулъя. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Энэ жилийн үлдсэн хугацаанд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 3 их наядаар давж орохоор ингэж

бид төлөвлөлөө. Сүүлийн 5 жил бид одоо тэнцвэржүүлсэн орлогоо төлөвлөхдөө нэг ч удаа алдаагүй, нэг ч удаа дутаагүй дандаа давж биелж байгаа. Энэ давсан хэмжээгээр бид нар одоо тэнцлээ сайжруулаад ингээд 5 жил явж ирлээ. Энэ удаагийн одоо үлдсэн хугацааны энэ төлөвлөлт дээр ч гэсэн алдаа гарахгүй болов уу гэж ингэж бодож байна. Ерөнхийдөө 3.1 их наяд төгрөг, үүний нэг 2.2 их наяд төгрөг нь бүтээн байгуулалтын томоохон ийм одоо зардлууд байгаа. Таны хэлж байгаа тоо 1.2 их наяд гэдгийг бол одоо ойролцоо хэлж байна.

Энэ дотор урсгал дотроо нэг удаагийн шинжтэй 4 томоохон зардал л байгаа. Энэ одоо таны сонгогдсон нийслэл хоттой холбоотой 584 тэрбум төгрөгийн Сэлбэ сэргэлттэй холбоотой сэлбийн голыг дагасан болон бусад ойролцоо энэ газар чөлөөлөлтийг хийе гэдэг энэ бүтээн байгуулалт, шинэ төлөвлөлтийг хийе гэдэг нийслэл Улаанбаатараас орж ирсэн саналыг Засгийн газар дэмжиж байгаа, дэмжиж байгаа.

Дээрээс нь одоо бид нарын 20 жил, 20 гаран жил үндсэндээ 30 жилдээ хийх гээд хийж чадахгүй явж ирсэн эрчим хүчний салбарын томоохон реформ либералчлалын шилжилтэд одоо чиглэсэн ийм зардал уг нь ЭХЯ-аас бол асуудал нь бол 1 их наяд төгрөгийн асуудал байгаа юм. Оруулж ирсэн нэг 220 тэрбум бид төсөв дээрээс нэг удаагийн татаас дэмжлэг буюу одоо тарифын чөлөөлөлт 11 сараас эхлэнэ гэж төлөвлөж байгаа. Тэр болтол одоо явж байгаа энэ системийн алдагдал доголдлыг нэг удаагийн татаасаар тэглэж одоо шилжилт хийх суурийг нь одоо засаж байна гэсэн үг. Ийм зардал.

Дээрээс нь Хүнс, хөдөө аж ахуйн салбар дээр 123 тэрбум төгрөгийн урсгал зардал нэмэгдэж байгаа. Энэ бол энэ жилийн зудтай шууд холбоотой, зудтай шууд холбоотой. Намар хийсэн одоо бид өөр жилд одоо суваг хурал дээр танилцуулж байсан. Энэ дагуу энэ одоо

малчны зээл болон хоршооны зээл энэ бас л энэ одоо хөдөө аж ахуй ялангуяа одоо уламжлалт МAA-н салбар дээр одоо хоршоожих суурь мал аж ахуй руу шилжих, эрчимжсэн МAA руу шилжих энэ томоохон одоо шилжилтийн зардлууд байгаа ийм байна. Ингээд том урсгал зардлууд дээр дүнгүүд нь ийм юм байгаа юм. Төрийн хуулийн төрийн худалдан авах ажиллагааны тухай хууль, Төрийн хөгжлийн тухай хууль дээр яг таны ярьж байгаа тэр өөрчлөлтүүд орсон байгаа. Энэ төр хувийн хэвшилтэй өрсөлдөх гээд байгаа юм биш яг эсрэгээрээ байхгүй юу.

Хувийн хэвшил ороод одоо дийлэхгүй зардал нь өндөр байна өртөг нь одоо төсөвт өртөг нь бага байна гээд ингээд сонирхохгүй орохгүй байгаа энэ төсвийг нь тавьчихсан байгаа. Хайран орон зайн дээр одоо болохгүй бол алдагдалтай ч хамаагүй цалинг нь даагаад тэр төрийн компаниуд нь тусгай зөвшөөрөлтэй энэ компаниуд нь ороод ажлыг нь хийчхээсэй. Хайран тавьсан төсвөө ингээд үрэн таран агаарт цацаад ингээд орхичихгүй юмсан гэдэг ийм л бодлого байхгүй юу. Тэрнээс биш төр хувийн хэвшилтэй өрсөлдөх гэж байгаа огт тийм зүйл байхгүй. Тийм. Нямбаатар сайд нэмж хариулъя гэж байх шиг байна.

Ц.Даваасүрэн: Нийслэлийн Засаг дарга Нямбаатар. Нэг номерын микрофон өгье. Баярлалаа.

Х.Нямбаатар: Би Ганхуяг гишүүний асуултад маш товчхон хариулъя аа. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд сая ажлын хэсэг дээр ярьж байгаад нэг заалт оруулсан нь нээлттэй тендерийг 2 удаа зарлахад нэг ч сонирхогч одоо этгээд аж ахуйн нэгж оролцоогүй бол тухайн чиг үүргийг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай тохиолдолд одоо төрийн болон орон нутгийн өмчит компаниар гүйцэтгүүлэх ийм зохицуулалт орж ирж байгаа юм. OECD буюу Европын аюулгүй байдал эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын санаачилгаар

Станбулын конвенц гэдэг авлигын эсрэг баримт бичиг батлагдсан. Уг авлигын эсрэг баримт бичигт төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах хуульд 2 удаа зарлаад манифляц хийж унагаагаад төрийн болон орон нутгийн өмчит компаниар гүйцэтгүүлж байгаа тохиолдолд энийг хориглож байгаа юм. Харин эсрэгээрээ 2 удаа зарлахад огт аж ахуйн нэгж оролцохгүй байгаа. Тухайн чиг үүргийг төр зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай тохиолдолд бид энэ зохицуулалтыг оруулж ирж байгаа. Өөрөөр хэлбэл Станбулын конвенцын үндсэн суурь шаардлагыг бид нар зөрчилгүйгээр нийцүүлж энэ өөрчлөлтийг оруулж ирж байгаа. Одоо жишээ нь бид энэ Улаанбаатар хотын маш олон явган хүний зам талбайг тохижуулах тендер зарлахад бараг дийлэнх багцууд дээр нь нэг ч аж ахуйн нэгж орж ирэхгүй байгаа.

Тэгээд энэ тохиолдолд иргэд болохоор энэ гудамжныхаа ус, явган хүний зам, цаашилаад энэ одоо хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд одоо хүртээмжтэй ийм хот больё энэ замаа зас гэдэг. Энх тайвны өргөн чөлөө, Их бага тойруу, Наадамчдын гудамж, одоо Олимпын гудамж гээд энэ замуудыг энэ жил бид нар бүхэлд нь шинэчилнэ гээд зураг төслийн хүрээлэнгээр зураг хийлгээд Барилга хөгжлийн төвөөр барилгын юугаа магадлуулаад тэгээд 5 багц тендер зарлахад 4 багц дээр ерөөсөө огт ААН-үүд оролцохгүй байгаа. Эрчим хүчний гудамжийг өргөтгөх ажлыг одоо 3 удаа зарлаад одоогоор ААН оролцоогүй байж байна. Энхтайваны өргөн чөлөө буюу бид нарын одоо хамгийн сайн мэддэг 25 дугаар эмийн сангаас Зүүн 4 зам хүртэлх замын ажлын тендерийг зарлаад бас ААН-үүд оролцохгүй байгаа. Энэ бол одоо бас ажиллах хүчний хомсдол байна. Бас олон ийм шалтгаанууд байх шиг байна аа. Бид нар зах зээлийнх нь жишигт нийцүүлж өнөөдрийн БХБ-ын сайдын баталсан тэр одоо аргачлал, норм, нормативын дагуу тодорхой ийм ажлуудыг зарладаг. Тэгээд замаа зас гээд ингээд одоо эргэж харддаг. Одоо жишээ нь Шар хадны зам гэхэд

машин явахын эцэсгүй байгаа тендер зарлаад ААН орохгүй.

Тэгэхээр бид нар энэ Станбулын конвенцыг зөрчилгүйгээр хоёуланд нь оролцоод орж ирээгүй тохиолдолд л гарцаагүй энэ чиг үүргийг хэрэгжүүлбэл гэж байгаа юм. Оролцоод тэр дотор нь зориуд унагаавал энийг манифляц гэж үзнэ гэж энэ конвенцод заасан байдаг. Тэгэхээр энийг зөрчөөгүй гэдгийг нэмж хэлье ээ.

Ц.Даваасүрэн: Ганхуяг гишүүн тодруулъя. Ганхуяг гишүүний микрофоныг өгье. Тэгээд энэ төсөв дээр зөвлөх үйлчилгээний зардал гээд 50 тэрбум төгрөг явж байна лээ. Хиймэл дагуулын хөтөлбөр гээд 68 тэрбум төгрөгийн бас хөрөнгө оруулалтын зардал явж байна лээ. Энэ 2 зөвлөх үйлчилгээний зардал нь би одоо нөгөө миний ойлгож байгаагаар метро нөгөө дүүжин гүүр болох юм болов уу гэж бодсон. Тэгээд энэ дээрээс нэг тодруулга авчихъя. Тэр сансартай холбоотой 68 тэрбумыг аваад байгаа юм. Тэр одоо яг манайд ач холбогдолтой тийм төсөл яваад байна.

Гуравт болохоор энэ Ганхуяг гишүүн хэдүүлээ нөгөө яг төсвийн хөрөнгө оруулалттай холбогдолтой юмнууд чинь маргааш байгаа шүү дээ. Одоо дагалдах хуулийнхаа хүрээнд тэр дагалдах хуулиас би дахиад ганцхан юм асуучихъя. Нөгөө тэр худалдан авах хууль дээр нэг сонгон шалгаруулалт хийхдээ чанар олон эд нар үнэлээд хамгийн сайн төслийг нь сонгож шалгаруулна гэсэн нэг тийм юу яваад байна лээ л дээ. Үнэлгээ хийхэд. Тэгээд хамгийн.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайдын микрофон 3 номер.

Б.Жавхлан: Даваасүрэн дарга би хэллээ дээ. Одоо бид чинь төсвийн хүрээ болон төсвийн хүрээг дагасан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд орж байгаа өөрчлөлт энийг л хэлэлцэж байгаа. Сая Ганхуяг гишүүнд хөрөнгө

оруулалттай холбоотой асуулт асуулаа. Тэр Төрийн худалдан авах ажиллагааны тухай хууль дээр тийм өөрчлөлт орж байгаа юм. Өөрөөр хэлбэл бид зөвхөн хямд үнээр шалгаруулдаг биш чанарын үзүүлэлтээр нь шалгаруулдаг энэ рүүгээ шилжээд одоо эхэлж байна гэсэн үг. Тэгэхдээ тэр чанар чадавх гэдгийг нэг удаагийн тендерт оролцож байгаа нэг удаагийн түүхээр бид нар шууд хийх боломжгүй.

Тэгэхээр энийг одоо төсвийн ерөнхийлөн захирагч бүр яамдууд бүр төрийн худалдан авах ажиллагааны газар бодлогын одоо чиглэл хариуцдаг яамдуудтайгаа хамтарч энэ одоо нөгөө нэг зээлийн түүх гэдэгтэй адил тендерт оролцож байгаа аж ахуйн нэгж одоо энэ компаниудын одоо зээл энэ юуг тендерт шалгарсан түүх гүйцэтгэл хийсэн түүх гээд энэ бүх зүйлүүд дээр нь үнэлгээ өгөх.

Ц.Даваасүрэн: Яах вэ Ганхуяг гишүүн нөгөө нэг төсвийн хүрээний хөрөнгө оруулалтын үзүүлэлттэй холбогдуулаад нэмэгдэж байгаа зардлыг асуугаад байх шиг байна. Дамдинням гишүүн асууя.

Г.Дамдинням: Төсвийн энэ тогтвортой байдлын зөвлөлөөс асуугаад тэгээд тэрэн дээр нь одоо бас Жавхлан сайд тодруулчихаар нь хариулна биз дээ. Яах вэ бид нар 2010 оноос хойш Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэдэг нэг ийм орон тооны бус зөвлөлтэй байж байгаад өнгөрсөн парламентын үед байх 2023, 2024 оны үед байна уу ямар ч байсан нэг байнгын ажиллагаатай ийм зөвлөлтэй болчихсон юм. Тэгээд байнгын ажиллагаатай зөвлөлийнх нь нэг анхны нэг гайгүй дүгнэлт нь орж ирж байх шиг байна. Тэгээд тэр нэг танилцуулгыг нь харж байхад бол үндсэндээ бид нар 10 оноос хойш 14 жилийн хугацаанд 17 удаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа өөрчилсөн байна лээ. Жилээс бараг жилд 2 удаа шахуу өөрчилдөг гэсэн үг шүү дээ тэр чинь. Тэгээд энэ бүрдээ төсвийн сахилга бат алдагдаж ингэж явдаг гэсэн ийм л дүгнэлтийг өгчихсөн байна лээ.

Тэгэхээр эндээс юу харагдаж байна гэхээр бид нар улам бүүр эрсдэлтэй болгоод байгаа юм байна л гэсэн. Энэ ойлгогдоод байгаа юм бол энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн өгсөн нэг ийм зөвлөмж байгаад байгаа юм аа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-д заасан нийт зарлагын өсөлтийг хязгаарласан шаардлагыг нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх хэмээн өөрчлөх нь төсвийн эрсдэлд нөлөөлөх гол хүчин зүйл болох, хөрөнгийн зардал болон цэвэр зээлийн жилийн өсөлтийг хязгаарлалтгүй болгох эрсдэл дагуулж байна гэсэн байна лээ. Энэ нь ямар учиртай юм. Энийг тайлбарлаад өгөөч. Тэгээд энэний тайлбарынх нь дараа Сангийн яам энэ дээр нэг хариулт өгөөдхөөч.

Энэ 1 дүгээр асуулт, 2 дугаар асуулт бол энэ юуны асуудал байна вэ? Тэр Худалдан авах ажиллагааны тухай хууль дээр тэр төрийн өмчийн компаниар гүйцэтгүүлнэ гээд тэгээд тендер зарлаад орж ирэхгүй байна гээд хотын дарга бас зовлон ярьж байна. Аймгийн дарга нар бүгдээрээ ярьдаг. Тэгвэл төрийн өмчийн компаниар цалинг нь өгөөд хийлгээд явахаар тэр компанийн чинь техник шинэчлэл, хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагаа, компани л бол компани шүү дээ орлого ашиг олоод явж байх ёстой. Тэгээд тэр зардлыг нь төсвөөс л өгнө гэсэн үг байхгүй юу. Ачаалал нь тэнд л очно гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр бизнесийн зарчим нь алдагдчихаад байгаа байхгүй юу. Тэгэхээр зүгээр хэдүүлээ ийм тэндээ амар хувилбараар шууд төрийн компанийг оруулж ирээд тэгээд төрийн оролцоог эдийн засагт улам их болгоод явах хувилбарын хооронд төсвийг нь дахиж хийх яаралтай горимоор шинэчилдэг энэ аргачлал руугаа шилжиж болдоггүй юм уу? Эд нар чинь баахан төрийн оролцоог бууруулна, төрийн компаниудыг тунгалаг болгоно, авлигал нь их байна гэж баахан ярьж байгаад орж ирсэн шүү дээ.

Тэгэхээр энэ том төслүүд тэгээд энэ хийгдэх гэж байгаа юмнууд чинь үндсэндээ тэгээд л төрийн ажил болно. Эргээд инфляц нь өснө. Тэгээд энэ нь ханишийн өсөлт болно. Энэ нь бүгдээрээ ард түмний нуруун дээр очих байхгүй юу. Тэгэхээр энийг 2 асуулт байгаад байгаа юм.

Ц.Даваасүрэн: Дамдинням гишүүний эхний асуулт тэр нөгөө нэг суурь зардал, суурь баланс гэдэгтэй чинь холбоотой байна. 6 номерын микрофон хариулъя. Ууганбаатар гишүүн Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн.

Э.Ууганбаатар: Гишүүний асуултад хариулъя.

Ц.Даваасүрэн: Ер нь энд тодорхой тэр нөгөө төсвийн хүрээний мэдэгдлээс төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ, хөрөнгө оруулалтын хэмжээ энэ тэрийг нөгөө үзүүлэлтүүдийг нь байхгүй болгочихсон энэ тэрийг нь оруулаад нэг тодорхой яриад ойлголт өгчих. Манай шинэ гишүүд бол энэний талаар нэг их сайн мэдээлэлгүй байгаа шүү дээ. Төсвийн хүрээний мэдэгдлийн талаар мөн төсвийн тогтворжилтын хуулийн талаар бас жоохон мэдээлэл дутуу байж магадгүй. Чи тэгээд дэлгэрэнгүй сайн тодорхой хэлээд өгчих.

Э.Ууганбаатар: Энэ төсвийн энэ тогтвортой байдлын хуульд заасан төсвийн тогтвортой байдлыг хангах төсвийн тусгай шаардлагууд гэж байдаг. Хоёр, гуравхан заалт байгаа. Ер нь бол. Засгийн газрын зардал нийт зардлын өсөлт ДНБ-ийхээ өсөлттэй баримжаатай байх ёстой гэсэн нэг заалт бий. Тэр нь үндсэндээ бол уул уурхайн бус ДНБ-ий өсөлтөөс давахгүй байх ёстой гэсэн заалт байгаа. Энэ заалтыг бол өөрчлөх санал орж ирсэн. Энийг өөрчлөөд яав гэж хэлж байна вэ гэхээр зөвхөн урсгал зардал дээр нь ДНБ-ий 30 хувь өгсөн тааз тавья гэсэн ийм санал оруулж ирж байгаа.

Тэгэхээр энэ нэг дагаад юу орох гээд байна вэ гэхээр төсвийн чинь доод талд хэд хэдэн янзын тэнцлүүд явагдана, хэд хэдэн янзын зардлууд явагдана. Энэ нэмэлт, өөрчлөлт орсноор манайд юу болох вэ гэхээр ашигтай гардаг 2 хувийн ашигтай гардаг нэг тэнцэл. Гэхдээ том зургаар нь харахаар өмнөх байснаасаа илүү том алдагдалтай гарах боломжтой бас нэг тэнцэлтэй болно. Тэгээд түрүүний 2 тэнцлийн асуудал бол энэ. Энэ дээр болохоор урсгал зардлыг нь зөвхөн урсгал зардал дээр нь өмнө нь бол нийт тэнцвэржүүлсэн зардал дээр үйлчилдэг байсан таазыг урсгал зардал дээр нь аваачаад үйлчлүүлчихээр цаад талд нь юу хяналтгүй хоцрох гээд байгаа вэ гэхээр хөрөнгийн зардал болон цэвэр зээлийн асуудал хяналтгүй хоцрох гээд байгаа.

Гэтэл Монгол шиг орныг төсвийн эрсдэлд учруулдаг хамгийн том асуудал юу байгаа вэ гэхээр зээлийн л асуудал байгаа шүү дээ. Ялангуяа гаднаас авч байгаа зээлүүд. Яг энийг хязгаарласан ийм заалтууд байхад энийг хамгийн их эрсдэлд оруулдаг зүйлүүдээ нөгөө хашсан хязгаарласан юмныхаа хажуу талаар нь л одоо гаргах гээд байна л даа. Тэгээд ийм учраас энэ бол төсвийн эрсдэлийг дагуулна. Шинэ 30 жилийг эрсдэлгүй 30 жил зоригтой гэхдээ эрсдэлгүй 30 жил болгомоор байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Хоёр дахь асуултад нь хэн хариулах юм? Хөрөнгө оруулалтын юм байна. Нямбаатар дарга хариулах юм уу? Нэг номерын микрофон өгье.

Х.Нямбаатар: Би Дамдинням гишүүний тэр асуултад хариулъя. Тэр саяын юуг Дамдинням гишүүн нөгөө том төсөл хөтөлбөрүүдтэй ерөөсөө энэ юуг хольж ойлгож болохгүй гэж хэлэх гэсэн юм. Өөрөөр хэлбэл жижиг аж ахуйн шинжтэй үйл ажиллагаанууд дээр удаа дараа тендерүүд зарлаад огт орохгүй байгаа тохиолдолд төсвийн шинэчлэл хийлгүй яах вэ. Тэгээд ч орохгүй байгаа тохиолдлууд байгаа.

Энэ тохиолдолд бид нар арга буюу л одоо энэ арга руу шилжиж тэр төрийн чиг үүрэг, хот нийтийн аж ахуйн чиг үүрэг дээр л яригдаж байгаа. Том төсөл хөтөлбөрүүд дээр бид нар энэ удаагийн Тендерийн хуульд селектив прокурмент гэдэг одоо энэ аргачлалыг бас оруулж ирж байгаа.

Өөрөөр хэлбэл бид нар мега төслүүд хэрэгжүүлэхэд жишээг худалдан авалттай яг адилхан нээлттэй дуудлага худалдаа тендер сонгон шалгаруулалт хийхээсээ илүүтэй тухайн дэлхийн хэмжээний одоо тэр салбарынхаа тэргүүлэгч ААН-үүдэд урилга хүргүүлээд урилгад одоо хариу ирүүлсэн байдлаар нь үнэлэлт өгдөг олон улсын одоо хөгжсөн орнуудын худалдан авах хуульд байдаг жишгүүдийг бид нар бас оруулж ирж байгаа гэдгийг бас хэлье ээ.

Тэгэхээр энэ саяын энэ 2 зүйл нь хоорондоо одоо давхцахгүй гэсэн энэ зохицуулалтыг хэлье. Мега төслүүд дээр хэзээ ч саяын ярьж байгаа тэр нөгөө Дамдинням гишүүний саяын асууж байгаагчлан юуг хэрэглэхгүй. Тэр нөгөө төрийн болон орон нутгийн өмчит компаниудыг оруулж ирэх тухай ойлголт байхгүй. Харин Худалдан авах тухай хуульд селектив прокурмент дээр бид нар тодорхой процессуудыг бичиж оруулсан байгаа гэдгийг хэлье.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайд нэг, дараа нь Загджав дарга тэр эхний асуултад бас аудит ямар дүгнэлт гаргаад байгааг нь нэг сонсоодохё.

Б.Жавхлан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн маань материалаа хүлээж аваад бас сайн танилцаж амжаагүй юм шиг байна аа. Одоо хугацаа хэрэгтэй байх. Хөрөнгө оруулалтын хязгаар гэж яриад байх юм. Одоо байгаа ч гэсэн хуульд энэ төсвийн тусгай шаардлага дээр хөрөнгө оруулалтын хязгаар гэж энэ зардлынх нь зориулалтаар нь хязгаарладаг хязгаар байдаггүй шүү дээ. Тусгай шаардлага гэдэг юм чинь 2 ч биш, 3 ч биш, 4 байдаг.

Орлого, зарлага, тэнцэл, өрийн хязгаар гээд. Тийм учраас энэ хязгаар тооцож байгаа аргачлал дээрээ өөрчлөлт оруулж байгаа л ийм л асуудал.

Эрсдэлтэй чиглэл рүүгээ явж байгаа биш харин ч эдийн засгийнхаа хөгжлийг бид нар дэмжээд, энэ өрийн зохицуулалт, өрийн ашиглалт дээрээ болон эргэн төлөлт дээрээ давхар ингээж зохицуулалт оруулж ирж байгаа бүүр тэрийгээ хуульчилж байгаа харин ч эрсдэлээ бууруулж явж байгаа ийм шинэ аргачлал байгаа шүү. Тэгээд энийг нэг арай жоохон зөрөө байдлаар тайлбарлаад байх юм. Ямар зорилготой юм би сайн ойлгохгүй л байна.

Ц.Даваасүрэн: Үгүй үгүй би ингээж ойлгоод байна шүү дээ. Нөгөө 9 үзэгдлүүдийг чинь нэг дээр нөгөө ДНБ-нд эзлэх хөрөнгө оруулалтын нийт хэмжээ гэсэн үзүүлэлтийг аваад хаячхаж байгаа шүү дээ. Тэрийг л яриад байх шиг байна л даа. Загджав дарга. Хэн нь хариулах юм? Нэг нь хариулчих. 5 уу? 5 дугаар микрофоныг өгье. Хэн байна? Самбууням Ерөнхий аудиторын орлогч аудитор.

Я.Самбууням: Гишүүний асуултад хариулъя аа.

Бид Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах дагалдах хуульд нь бол дүгнэлт гаргасан. Тэгээд энэ дээр бол бид дүгнэлт дээрээ цаашид дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахгүй байх, төсвийн тусгай шаардлагын дунд, урт хугацаанд тогтвортой байдлыг хадгалж дагаж мөрдөх нь төсвийн тогтвортой байдлыг бэхжүүлэх суурь нөхцөл боллоо гэсэн дүгнэлтийг өгсөн байгаа.

Ц.Даваасүрэн: Тэр яах вэ өөрчлөхгүй л гэсэн дүгнэлт өгсөн юм байна л даа. Нөгөө тийм төсвийн 9 үзүүлэлтээ хэвээр нь байлгах ёстой тогтвортой байлгах ёстой л гэсэн дүгнэлт өгсөн юм байна тийм үү? Та нар тэр нягтлан бодох бүртгэлийн тэр гафтай холбогдолтой юун дээр нь

маргааш дүгнэлтээ оруулахдаа бас нэг тэрийг нэг харчихна шүү за юу. Ойлголоо тодруулах юм уу? Дамдинням гишүүн тодруулъя.

Г.Дамдинням: Нэгдүгээрт энэ гишүүдэд, бид нарт бас энэ мэдээллээ их эртхэн өгмөөр байна. Тэгээд бид нар ч бас мэдэж уншиж амжихгүй байна шүү дээ. Тэгээд өнөөдөр л орж ирлээ. Түрүүний яах вэ одоо ингээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бол өр нэмэгдэх гээд байна л гэдэг маш товчхон дүгнэлтээ өгч байна шүү дээ. Тэгж ойлгогдож байна. Сангийн сайдаас асуухад энэ төсөв ингээд батлагдаад явахаар манай гадаад өр нэмэгдэх үү, нэмэгдвэл хэр их хэмжээгээр нэмэгдэх вэ? Ийм асуулт байна.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайдын микрофон 3 номер. Хариулъя.

Б.Жавхлан: Өрийн тооцоолол дээр номинал тооцоолол дээр өөрчлөлт орно. Бид ерөөсөө 90 оноос хойш өнөөгийн үнэ цэнээр одоо өрөө тооцож ирсэн. Өөрөөр хэлбэл ОУВС одоо гаднын одоо санхүүгийн байгууллагууд энэ чинь буруу шүү, эрсдэлтэйгээр одоо та нар тохиргоо хийж номинал дүнгээр тооцож яваарай гэж бид нар үндсэндээ бараг сүүлийн 30 жил шаардаж байгаа. Үе үеийн цөөнх талаас ч гэсэн энэ ийм шаардлагууд тавьдаг. Тэгвэл бид нар энэ удаагийн одоо өөрөөр хэлбэл одоо сүүлийн 4-өөс 5 жил сахилга баттай явж ирсний үр дүнд гадаад өр талдаа шүү. Бид нар нэлээд том орон зай онгойж байгаа. Номинал дүнгээрээ бол нэг 15, 16 их наядын гэх үү дээ. Гүйцэтгэл бол өрийн үлдэгдэл, дотоодын бүтээгдэхүүний одоо тааз нь 60, гүйцэтгэл нь 39 хувь дээр гарч ирж байгаа. 20 хувийн нөөц гарч ирж байна гэсэн үг. Номинал руугаа, тооцоолол руугаа шилжихээр 39 биш, 45 хувь болж гарч ирнэ. 45 хувь.

Ц.Даваасүрэн: Тийм өөр өөр яах вэ нөгөө номинал утгаар нь энэ дэлхий нийтийн чиг хандлага тийм болчихсон. Тэр талаас нь энэ нэг их буруу өөрчлөлт биш байх зүгээр түрүүний хэлээд байгаа

тэр нөгөө суурь зардал гэдэг дотроо гадаад зээлээ оруулахгүй байна шүү гэдэг асуудлыг л эд нар яриад байгаа байхгүй юу.

Дараагийн гишүүн Мэндсайхан гишүүн асуултаа асууя.

3.Мэндсайхан: Энэ гадаад зээл бондыг эх үүсвэртэй гээд юунаас зардлын өсөлтийг тооцох аргачлалаас гаргахыя гээд ерөнхийдөө би одоо тэгж л ойлгоод байгаа юм. Тэгэхээр энэ нөгөө Засгийн газрын өр сая би бас сонсоод л суугаад байна. Засгийн газрын өр гадаад зээл одоо төсвөөс гадуур явчих тийм эрсдэл байгаа юм уу? Ямар учиртай одоо энэ зардлын ангиллыг өөрчлөөд байгаа юм бэ? Ер нь тэр өрийг нэрлэсэн дүнгээр тооцдог болсноор Засгийн газрын маань өр ДНБ-ий одоо 30 хувиас хэтрэхгүй гэж байна шүү дээ. Яг одоо энэ хэрэглэхээр хөгжлийн хөтөлбөрүүдийг зардлуудыг хэрэгжүүлснээрээ хэдэн хувь болох гээд байгаа гэдгийг л нэг тодорхой ярьчихлаа, хэлээд өгөөч гэдэг асуулт байна.

Хоёрдугаарт Жавхлан сайдаа ер нь зүгээр нөгөө нэгжийн тухай хуулиараа бид нар нэг өмнө нь Засаг дарга нар концесс хийгээд л тус тусдаа нэг яваад байсныг нэг хязгаарласан шүү дээ тийм ээ. Тэгэхээр нийслэлтэй барьцаж байгаа асуудал байна шүү дээ. Нийслэл ингээд бие даагаад бонд гаргаад явахаар хэдийгээр Засгийн газар зөвшөөрөл өгч байгаа ч гэсэн цаашидаа аймгууд ийм үнэт цаас гаргаад явах боломж нээгдэж байна уу? Энэ чинь нэг тийм төсвийн тогтвортой байдал дээрээ ямар эрсдэл дагуулж байна гэдгийг л тодорхой хэлээд өгөөч.

Ц.Даваасүрэн: 3 номерын микрофон. Жавхлан сайдын микрофоныг өгье. Хариулъя.

Б.Жавхлан: Гадаад өрийн хязгаар 60 хувь гэж одоо хууль дээр байгаа энэ хэвээрээ байна. 30 хувь суурь зардал шүү. Суурь зардлын хязгаар 30 хувь гээд ийм хязгаарууд байгаа. Нийслэл дээр сая нэгжийн хууль дээр өөрчлөлт ороод

нийслэл орон нутаг, орон нутаг гэдгийг Ерөнхий хэллэгээрээ тэрэн дотор нийслэл нь орчхож байгаа. Гэхдээ сүүлийн одоо 3-аас доошгүй жил одоо Монгол Улсын төсөвт одоо орлого төвлөрүүлдэг санхүүгийн хувьд бие даасан ийм одоо орон нутгийн институцүүд тэрэн дотор ингээд нийслэл орчхож байгаа. Тодорхой хэдэн цөөхөн аймгууд орж байгаа. Эдгээр одоо нэгжүүд одоо үнэт цаас гаргах ийм эрх нь нээгдсэн. УИХ дээр одоо энэ асуудал өргөн баригдаад Засгийн газраас өргөн бариагүй. Энэ асуудал ингээд шийдэгдээд ингээд явж байгаа.

Ц.Даваасүрэн: Мэндсайхан гишүүн болчихсон уу, тодруулъя. Мэндсайхан гишүүний микрофон.

3.Мэндсайхан: Тэр ДНБ-ий хэдэн хувьд эзэлж байгаа гэдэгт нь яах вэ би яг нөгөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа яг энэ заалт чинь хангаад заалтыг нь хангаад явж чадаж байгаа юм уу? Одоо яг зөрчил гараад байгаа юм уу? Энэ төсвийн зөвлөлөөс гаргаж байгаа дүгнэлттэй та бүгдийн маань тайлбар 1 мөр өгчихмөөр байх юм.

Ц.Даваасүрэн: Өр дээр тийм үү нөгөө өнөөгийн үнэ цэнийг номинал болгосон нь нэг хязгаартай байгаа юу л гээд байгаа юм байна. Жавхлан гишүүн хариулъя.

Б.Жавхлан: Төсөвт өртгийн байдлын зөвлөлийнхөн маань яриад байгаа нь цаашдаа гэж яриад байгаа юм. Энэ оны 24 он болон өмнөх жилүүд дээр бол ямар ч зөрчил үүсээгүй, бүх одоо тусгай шаардлагуудаа хангаад явж байгаа төсөв.

Ц.Даваасүрэн: Сонсогдохгүй байна.

Б.Жавхлан: Би одоо байдгаараа л орлиод яриад байна.

Ц.Даваасүрэн: Энэ микрофоныхоо тохиргоог сайн хийе манай техникийнхэн

ахиад суларчихсан юм шиг байна. Минийх ч гэсэн сул болчихсон байна уу?

Б.Жавхлан: Мэндсайхан гишүүн тэр сая миний асуултыг сонссон сонсчихсон байх тэ?

Ц.Даваасүрэн: Ойлгочихсон уу? Ойлгочихсон бол Алтанхуяг гишүүн асуултаа асуучихъя. Энэ хугацаанд микрофоныг нь чангалъя байна уу?

Энэ бас байхгүй байна шүү дээ чангалаад өг дөө байна уу? Үгүй түрүүн минийхийг чинь бүр орилуулаад л байсан шүү дээ тэ? Тийм харин дахиад одоо боломжгүй байгаа. Боломжгүй байна.

Хурал дууссаны дараа тохиргоо хийнэ. Одоо байна шүү дээ. Нөгөө энэ тохиргоо хийх цаг хугацаагүй болчихоод байгаа юм байна. Тэгээд хэдүүлээ аль болох л одоо зохицуулъя. Бүгдийг нь унтраачхаад асаачихгүй юу? Байна уу? Жаахан орилоод ярьчих уу? 2 минут өнгөрчихсөн явж байна.

Н.Алтанхуяг: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Энэ их чухал хууль болж орж ирж байгаа шүү. Сая хэн хэлчэв. 14 жилд 17 удаа өөрчилсөн. Уг нь хуулийнх нь нэр нь тогтвортой байх ёстой гэдэг хууль байхгүй юу. Тэгээд 14 жилд 17 өөрчилсөн. Одоо бас өөрчилж болохгүй ээ. Би энэ Тэмүүлэн дарга бас Төсвийн байнгын хорооны дарга байсан бас юм цэгцлэх гэж оролдсон. Одоо ингэж болохгүй Жавхлан. Тэгээд цагийг нь тулгаж юм өгчхөөд бид нарыг юм уншиж ойлгодоггүй хүн шиг загнаад байж хэрэггүй.

Наана чинь Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэж аргаа бараад энэ Улсын Их Хурал бий болгосон юм шүү дээ. Тэгээд бид нар ч бас уншиж амжихгүй нь. Зарим нь амждаггүй. Тэгэхээр эд нар чинь мэргэжлийн хүмүүс. Наана чинь мэргэжлийнхээ хэлээр бодоод яриад байна шүү дээ. Одоо хэрэггүй ээ, болио,

ийм хууль орж болохгүй. Ийм хууль ярьж ч болохгүй.

Нэгдүгээрт Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах ямар ч шаардлага байхгүй.

Юун аргачлал хуучин аргачлалаараа л яв. Одоо гадаадын зээл тусламжийн ДНБ-д эзлэх хувь юм уу, янз бүрийн тоонууд бүгд дагаж гүйнэ, алга болно, ингээд бөөн хэрүүл болно. Тэгээд бид нар сүүлд нь баталсан хэрэгтээ орно. Хөөе гишүүд би та нарыг бас нөгөө янз бүрийн юмнаасаа аврах гээд байна шүү дээ. Тэгэхээр ийм юм ярьж болохгүй.

Хоёрдугаарт төсвийн хүрээний мэдлэгийг ингэж өөрчилж болохгүй.

3.1 их наядаар одоо тас хийтэл өөрчлөөд яваад байдаг. Тэгээд 3.6 тэгээд 4.9 ойрын 3 жилд ингээд зарлагыг бол ийм их айхтар өсгөнө. 12 их наядаар өөрчилнө. Хөөш энэ Ардын намынхан би та нарт нэг юм хэлчихье. Ардын нам гэж одоо энэ хамтарсан маягийн юм болчихлоо. Хамтраад юм хийнэ гэдэг чинь хамтраад юм дордуулна гэсэн үг ерөөсөө биш шүү. Жаахан цэгцтэй байгаарай анхнаасаа. Тэгэхээр энэ төсвийн зарлага чинь энэ манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн их чухал цаас тараасан шүү дээ. Та нар харсан уу үгүй юу. Манай энэ татвар ДНБ-д манай энэ төсвийн орлогын эзэлж байгаа хувь чинь 34 хувь болчихоод байгаа юм. Гэтэл нөгөө данхар том хөгжилтэй орон чинь 38 хувьтай явж байгаа шүү дээ. Үгүй хөгжлийнх нь түвшинийг аваад үзвэл манайх бүүр тээр доор байгаа мөртөө хурааж байгаа одоо орж байгаа орлого нь бол 34 хувь болчихсон цохиж яваа. Хэд байх ёстой гээч 29 байх ёстой. Одоо Ардын намынхан та нар байна шүү дээ. Татвар бууруулмаар байна, НДШ бууруулмаар байна. Хувийн хэвшилээ алж унагаах биш хувийн хэвшлийг жаахан тэжээмээр байна. Бодлогоо ингэж гарга, тэгж хий, одоо боль л доо. Ингээд үгүй энэ Жавхлан нөхөр чинь өнгөрсөн 4 жил хийгээ биз дээ. Одоо эсвэл соль та нар. Жаахан ингээд нэг

конструктив ханддаг энэ улс орноо боддог, хувийн хэвшилээ дэмждэг төрийг данхайлгаад л, дарга нарыг данхайлгаад л сонгуулиа хүртэл мөнгөөр худалдаж аваад ингээд байхаар энэ улс яаж хөгжих юм.

Би их тодорхой санал хэллээ шүү. Жавхлан ганцхан тоо хэлчих. Өнөөдөр Монгол Улсын гадаад өрийг хэд гэж байгаа вэ? Тэрэн дотор Засгийн газрын өр хэд гэдэг тоотой байна. Би хоёрхон тоо сонсчихъё. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайдын микрофон 3, хариулъя.

Б.Жавхлан: Өнгөрсөн оны 2023 оны гүйцэтгэлээр гадаад өр дотоод нөөцөд эзлэх хувь хэмжээ нь 39 хувь байгаа. 39 хувь дүнгээрээ 8.1 тэрбум доллар байгаа. Засгийн газрын өр шүү. Монгол Улсын өр биш, Засгийн газрын өр.

Ц.Даваасүрэн: Түвшин асуултаа асууя. Түвшин гишүүн.

Б.Түвшин: Баярлалаа. Ер нь ихэнх асуулт давхцаж байгаа учраас тодорхой хоёр, гуравхан санал нэг хэлчихье ээ. Ер нь манай улсын төсвийн орлого ДНБ-д 34 хувь эзэлж байгаа гээд байгаа. Засгийн газар, хамтарсан Засгийн газар байгуулснаараа асар их томоохон өөрчлөлт хийх боломж бүрдэж байгаа гэж ойлгож байгаа.

Тийм учраас энэ зайлиггүй явуулах томоохон хэмжээний хөрөнгө оруулалтуудыг хийх нь зөв өө. Гэхдээ урьд нь байгаа урсгал зардлаа хасаад одоо энэ шинээр зайлиггүй гэж байгаа хөрөнгө оруулалтуудаа зоригтой оруулаад ирээч ээ. Одоо нэгэнт хамтарсан юм бол элдэв долоон зардал хасахад чинь бол бас шүүмжлэл байхгүй байх.

Хоёрдугаарт энэ 34 хувийг буулгахын тулд нэмэгдсэн өртгийн албан татварыг 50 хувь, нийгмийн даатгалыг тодорхой хязгаартай болгоод бусад үйл ажиллагааны орлогоос авдгийг нь хасчих

юм бол нөгөө бизнесийн сектор чинь босоод ирнэ. Одоо яг үнэндээ бол бизнесийн секторууд нийгмийн даатгал нэмэгдсэн өртгийн албан татвараас болоод сөхөрч унаж байна. Аль ч салбар нь. Уул уурхайн салбараас бусад нь бараг л одоо дуусчих шиг боллоо.

Тэгэхээр энэ бол хамтарсан Засгийн газрын хамгийн том эдийн засгийн бодлого байх болов уу. Нөгөө талаасаа бид нарын төсвийн орлого бол 30 хувьдаа бариад, 30 хувийн одоо орлогоо цуглуулаад энэ эдийн засгийг үр ашигтайгаар удирдах боломж бүрдэж байна гэж үзэж байна.

Гуравдугаарт тэр төсвийн хүрээний харьцаануудыг өөрчилж болохгүй ээ. Тогтвортой байдлын хуулийг өөрчилж болохгүй. Ерөөсөө энэ бүх зүйл зардал байхгүй юу. Хөрөнгийн зардал гэж нэрлэнэ үү, урсгал зардал гэж нэрлэнэ үү? Сүүлдээ бид нар чинь гоё нэртэй болчихсон шүү дээ. Том төслийн зардал, хөрөнгө оруулалтын зардал, гарсан л бол гарсан, зарсан л зарсан шүү дээ. Тэгээд энэ ангилууд нь бол хүний толгой хувирч байгаа юм шиг эцсийн үр дүндээ л байгаа. Том төсөл гэдгийг юу гэж ойлгох вэ гэхлээрээ үр өгөөжтэй эдийн засаг нийтэд ашигтай гэж байгаа юм. Одоо энийг бол энэ Их Хуралд сууж байгаа хүмүүс Засгийн газрын гишүүд өөрсдийнхөө ойлгоцоороо тайлбарладаг болчихсон.

Гэтэл энэ үнэхээр нийгэм эдийн засагт ашигтай юм уу эргээд энэ салбарт ашигтай юм уу эргээд өгөөжөө өгөх юм уу гэдгийг үнэлдэг. Төслийг хөтөлбөртөө үнэлдэг мэргэжлийн байгууллагуудыг бид нар бас бойжуулж дүгнэлт авдаг байхгүй бол хэн одоо паналтай, хэн уран цэцэн үгтэй нь бүх юмаа том төсөл, хөрөнгө оруулалт, үр ашигтай энэ тэр гэж нэрлээд оруулж ирдэг. Эцсийн дүндээ Засгийн газрын өр л нэмэгдэж байдаг.

Гуравдугаарт түрүүний тэр төсвийн одоо байдал дээр одоо тооцдог тооцооллууд дээр мөнгөн сууриар тооцно

гэж байна, тэр болохгүй. Ерөөсөө тэр IFR-аас сууриар тооцно гэдэг чинь мөнгө нь орж ирснээс үл хамаараад олон улсын болон гадаадын байгууллагын өмнө хүлээсэн үүргээрээ бүртгэдэг зарчмыг бид нар авсан мөнгөөрөө явчхаж байгаа юм. Гэрээ нь томоороо байж байгаа шүү дээ. Энэ бол тооцооллын арга дээр бол Монгол Улсын төсвийн тооцооллын эрсдэлд оруулна.

Тийм учраас дахиад эцэст нь хэлчихье. Өнөөдөр хэдүүлээ төсвийн урсгал зардлыг бууруулж энэ хоёр томоохон татварыг бууруулаад төсвийнхөө эзлэх хувийг 30 хувьд хүргэчихье ээ. Энэ тооцоолол болохоор байна уу Жавхлан сайдаа?

Ц.Даваасүрэн: Нэг минутаа нэмээд өгчихье. Түвшин гишүүний нэг минутыг нэмье. Санал хэлж байгаа юм байна шүү дээ тийм ээ.

Б.Түвшин: Тийм. Энэ төсвийн асуудлын тодотголыг хэлэлцэж байх үед Төсвийн тогтвортой байдлын хуулийг хэлэлцэхгүй байя. Төсвийн тогтвортой байдлын хуулийг хэлэлцэж болно. Тэрийг шал өөр үед тооцооллын аргыг нь өөрчилдөг, тогтвортой байдлаа чангатгадаг, бууруулдаг байж болно. Энэ нь төсөв оруулж ирж байгаа этгээдийн оруулж ирдэг биш Их Хурлын одоо гишүүдийн ч юм уу Их Хурлын үүрэг байвал бас болж л байна. Түүнээс биш өөрчилж болно. Төсөвтэй холбогдож орж ирэхээрээ энэ чинь шулуухандаа хэлэхэд нөгөө бид нарын хэлдэг ашиг сонирхлын зөрчил чинь одоо өөрөө энэ шүү дээ.

Тийм учраас IFR-ыг өөрчлөөд бид нар орлого зардлаа янз янзын аргаар өөрчлөөд явчих юм бол Монгол Улсын төсөв ойлгогдохооргүй болно.

Хоёрдугаарт бүх зүйлийг зардал гэдгээ ойлгоё. Тэр нэр томъёонуудыг өөрчлөхөө больчихъё. Хөрөнгийн зардал гэдэг агуулгаас ч гэсэн бодолтой. Хөрөнгө гэдэг чинь өөр агуулгадаа зардал гэдэг ч

гэсэн бодолтой. Хөрөнгө гэдэг чинь өөр агуулгатай зардал гээд тэгээд ердөө тэр 2-ыг нийлүүлээд тавьчихаар яг юу гээд байгаа юм? Ийм ийм хөрөнгө оруулалтын зардал ч гэсэн жишээтэй. Ийм учраас энэ ядаж нэр томъёо нь одоо олон улсын стандартад нийцсэн.

Ц.Даваасүрэн: Хугацаа дууслаа. Манай гишүүд анхаараарай. Энэ асуулт асуугаад хариулт дутуу бол нэг минут нэмж өгнө шүү. Би зүгээр сая яах вэ түрүүн эхний удаа асууж байгаа учраас нэмээд өгчихлөө. Асуулт асуугаад тэгээд хариулт дутуу байх юм бол нэг минут нэмж авна.

Булгантуяа гишүүн асуултаа асууя.

Х.Булгантуяа: Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр оруулж байгаа өөрчлөлтөөс нэрлэсэн дүнгээр тооцно гэдэг зөв өө. Энийг бид нарт нэлээн олон жил олон улсын байгууллагуудаас зөвлөж байсан. Тэгээд 1 асуулт байна. Одоо нэрлэсэн дүнгээр яах юм бол одоогийн өрийн хэмжээ хэрхэн яаж нэмэгдэхээр байна вэ?

Хоёр дахь нь ахиад үнэт цаас гадаад зээлээр санхүүжих зардлыг оруулахгүйгээр нэгдсэн төсвийн суурь зарлага гэж гаргая гэж байгаа юм байна. Тэгээд ахиад төр хувийн хэвшлийн тэмцлийн тухай хуулиараа нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг одоо хэвийн тасралтгүй хангах нэн яаралтай нөхцөл үүссэн. Ер нь шууд гэрээ байгуулах нөхцөл үүсэх юм байна. Ингээд тэр нь ер нь бол одоо бараг улаан шугамаас доогуур ахиад нэг зураас юу татаад дахиж нэг тэнцэл шиг юм явах юмуудаа одоо тэгж л ойлгогдлоо.

Тэгэхээр хэрвээ төлж чадахгүй бол яах вэ? Одоо улсын төсөвт төвлөрүүлж байгаа дөрөв, тавхан аймаг байгаа. Тэд нар эдгээр аймгууд л ер нь бонд гаргах юм байна аа. Нийслэл бас тийм эрх өнөөдөр төсөв санхүүжилт байна гэж ойлгож байгаа. Гэхдээ гадаадын улс орнуудад

хэрвээ тэгж чадахгүй бол Засгийн газар үнэнээс нь төлөх үү? Хэрвээ бонд гаргаад нийслэл өөрөө төлж чадахгүй бол аймаг, дараагийн аймаг жишээлбэл өөрөө бонд гаргаад төлж чадахгүй. Засгийн газар энийг төлөх үү? Эс үгүй бол төсвийн хариуцлагыг нь тэр чигээр нь тэр аймагт нь үүрүүлж байгаа юу? Тийм тохиолдолд одоо зарим улс орнуудын жишээ хайр найргүй хамаг юмыг нь зардаг. Автомашинаас нь авхуулаад бараг суудаг барилгаас нь авхуулаад зарим газруудыг нь түрээслээд зараад одоо тийм арга хэмжээ авдаг. Тэгж чадах уу?

Тэгэхээр хэрвээ нэгэнт л одоо эрх мэдлийг нь өгч байгаа юм бол нөгөө талд нь хариуцлага нь яг давхар явах ёстой. Тийм зүйл нь бас байна уу, үгүй юу гэдэг ийм эхлээд асуултыг тавих гэсэн юм.

Ц.Даваасүрэн: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Сангийн сайдын микрофон 3. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Энэ батлагдчихсан хууль л даа. Орон нутагт ийм эрх мэдэл өгчхөж байгаа юм. Яах вэ санхүүгийн хувьд одоо чадамжтай гэдгийг энд одоо сүүлийн 3-аас доошгүй жил улсын төсөвт одоо орлого төвлөрүүлж байгаа. Одоо өөрөөр хэлбэл зарлагаа өөрсдөө нөхдөг. Харьцангуй санхүүгийн бие даасан ийм аймгуудад. Тэгэхдээ Засгийн газар зөвшөөрөл өгнө. Одоо жишээ нь хавар өмнөх Засгийн газраар нийслэлд зөвшөөрөл олгосон зарцуулах гэж байгаа төслүүд санхүүжүүлэх гэж байгаа төслүүдийг нь авч үзэж байгаад нэн шаардлагатай яг тулгамдсан асуудлууддаа одоо мөнгө шаардлагатай болоод бонд гаргах гэж байгаа юм байна аа. Энэнээс одоо хоёр ч транстай байгаа. 3-аас 5 жилийн хугацаатай энэ хугацаанд нийслэл өөрөө энийгээ төлнө төсөл дээр ямар нэг ачаалал авч явахгүйгээр тооцоолж эрсдэлийг тооцоолж Засгийн газар зөвшөөрөл өгдөг гэсэн үг.

Аймгууд дээр ч гэсэн зөвшөөрөлгүй Засгийн газар өгнө. Санхүүгийн

хариуцлагаа аймгууд өөрсдөө хариуцаад явах тийм чадамжтай. Тийм одоо эргэн төлөгдөх дамжуулан ч юм уу ийм одоо төслүүдийг санхүүжүүлнэ гэдгийг ингээж тооцоолж өгч байгаа гэж хуульчилчихсан юм байна лээ. Тэгээд энэ хуулийн дагуу явж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл энэ удаагийн тодотгол дээр энэ орж ирж байгаа нь бондоо босгох мөнгөө босгох эрхийг нь хуулиар өгчихсөн, зарлагадах эрхийг нь бид төсвийн тодотголоор өгч байгаа гэсэн үг. Энэний дараа нийслэл дагаад тодотголоо хийгээд энэ босгочихсон мөнгөөрөө ийм ийм зүйлийг санхүүжүүлнэ ингээж эргээж төлүүлнэ гэдгийгээ өөрсдөө тодотгоод явах юм байгаа юм.

Ц.Даваасүрэн: Тэр шууд хэрэг нөгөө номинал болохоор өрийн хэмжээ тийм дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаанд өөрчлөлт гарч байна уу гээд байгаа юм. Тэгээд хариулъя. Тэгээд хөөш Санхүүгийн зохицуулах хороо чинь бас нэг бонд гаргахад дүгнэлт гаргаж байгаа тэрийг бас нэмээд хэлчих.

Б.Жавхлан: Булгантуяа гишүүн ээ ингээж байгаа. Түрүүн Дамдинням гишүүн бас асуучихсан асууж байсан. Одоо хязгаар маань 60 хувь 2023 оны гүйцэтгэлээр 39 хувь болж байгаа юм. Гүйцэтгэл нь номинал руу шилжихээр энэ 44 орчим гарна. 44.7хувь гарч байгаа юм. 4-5 хувийн ийм тооцоолол номинал руугаа шилжиж тохиргоо хийгдэнэ гэсэн үг.

Тэрнээс өрийн хэмжээ нэмж өр нэмэгдэж байгаа асуудал биш шүү. Өөрөөр хэлбэл бид нар эрсдэлтэй түвшинээр хамгийн эрсдэлтэй түвшинээр олон улсын жишгээр тооцож цаашаа явна л гэсэн үг.

Ц.Даваасүрэн: Бонд гаргахад чинь бас Санхүүгийн зохицуулах хороо дүгнэлт гаргаж байгаа шүү дээ? Нэлээн юутай бас одоо тэр иргэд төлөгдөх боломжтой юу үгүй юу гэсэн тэр талаас нь Санхүүгийн зохицуулах хороо дүгнэлт гаргаж байгаа. Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя.

Дутуу байгаа юм уу? Тэгвэл гүйцээчихье Нямбаатар дарга тэр төр хувийн хэвшилтэй холбогдолтой асуултад нь хариулъя. Булгантуяа гишүүний.

Х.Нямбаатар: Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль сая 2022 онд батлагдаад, сая 2024 оны 1 сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Энэ хууль Эдийн засаг хөгжлийн яаман дээр төр хувийн хэвшлийн түншлэлийн одоо жагсаалтуудыг гаргаж, Засгийн газрын хуралдаанаар батлуулж төр хувийн хэвшлийн түншлэлийг зохион байгуулах процедур нь Засгийн газар Эдийн засгийн хөгжлийн яаман дээр төвлөрсөн ийм тогтолцоотой байсныг сая бид 6 дугаар сард 5 сард оруулсан. Их Хуралд оруулсан өөрчлөлтөөр нийслэл гээд таслал тавиад сүүлийн 3 жил дараалан улсын төсөвт орлого төвлөрүүлсэн. Аймгууд дараах 5 төрлийн одоо чиглэлээр төр хувийн хэвшлийн түншлэл хийх эрхийг авсан. Эрчим хүчний төсөл хөтөлбөр, зам гүүрийн байгууламж, дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүд хүнс хангамжийн ийм төсөл хөтөлбөрүүд дээр дурдсан аймаг, нийслэл төр хувийн хэвшлийн түншлэлээ өөрөө зарлаад нээлттэй зарлаад сонгон шалгаруулалт хийгээд ВОТ нөхцөлөөр одоо төр хувийн хэвшлийн түншлэл хийх ийм эрх зүйг бий болгож байгаа гэж ойлгож болно. Энэ хуулийн хэрэгжилтийг одоо энэ төсөв дагасан хуулийн өөрчлөлттэй хамт хугацааг нь нааш татаж энэ төсвийн тодотголтой цуг хэрэгжүүлж эхлэхээр зааж байгаа юм.

Сая гишүүд бас нэлээдгүй зүйл ярьж байна. Монгол Улсын өрийн удирдлагын тухай хууль болон төсвийн одоо шаардлага шалгууртай холбоотой олон зүйл хөрөнгө оруулалттай холбоотой ийм өр үүсэх эрсдэлийн талаар ярьж байна.

Тэгэхээр үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд төр хувийн хэвшлийн түншлэлийн энэ хэрэгслийг бид энэ томоохон бүтээн байгуулалтууд дээр

ашиглая гэдэг ийм одоо зорилготой байгаа. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд бас нэг орсон өөрчлөлт дээр дурдсан 5 чиглэлээс гадна дээр дурдсан одоо субъектүүд чиглэл харгалзахгүй 100 тэрбум хүртэлх төгрөгийн одоо бүтээн байгуулалтын ажил дээр төр хувийн хэвшлийн түншлэлийг ашиглая. Ингэхдээ мөн төсвөөс зардал гаргахгүй эргээд эргэн төлөгдөхгүй, тодорхой тарифт үйлчилгээнүүдийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж гэдэг ийм нэмэлт, өөрчлөлтүүд батлагдсан. Энэ хугацаанаас татагдаж байгаа гэж ойлгож болно.

Шууд гэрээ юм уу? Тэгвэл Булгантуяа гишүүн тодруулчихъя.

Х.Булгантуяа: Төр хувийн хэвшлийн түншлэлээр олон ажлуудыг хийхийг дэмжиж байгаа юм аа. Энэ шинээр оруулж байгаа зүйл, заалт нь 37.1.3 нь сонгон шалгаруулалтгүйгээр гэрээ хэлэлцээ хийж болно гэдэг зүйл, заалт дээр оюуны өмчийн эрхтэй холбоотой асуудлыг бид нар ойлгож байна. Онц нөхцөл байдал гамшгаас хамгаалахад бэлэн байдалд шилжсэн тохиолдолд гэдгийг ойлгож байна. Түүн дээр ахиад нэмэгдээд нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний хэвийн тасралтгүй хангах одоо нэн яаралтай нөхцөл үүссэн тохиолдолд гээд энэ нь одоо их л олон юунуудыг шууд гэрээ байгуулах нөхцөлийг үүсгэх юм биш биз дээ л гэдэг ийм асуултыг тавиад байгаа юм. Өөрөөр хэлбэл нэг талдаа одоо ингээд бүртгэл талдаа болохоороо нэгдсэн төсвийн зарлагаасаа хасаж байгаад тэгээд шууд гэрээ байгуулаад ингээд явчих эрх зүйн орчин чинь бий болчихож байгаа юм биш биз дээ?

Ц.Даваасүрэн: Худалдан авахын хуультай холбогдолтой асуудал байна. Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Бид ажлын хэсэг дээр бас энэ асуудлыг яриад төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар 3 түвшинд

одоо төр хувийн хэвшлийн түншлэлийн харилцаа үүсгэж болно гээд одоо дийлэнх тохиолдолд төр хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг, төр хувийн хэвшлийн түншлэл байгуулах эрх бүхий субъектүүд нээлттэй сонгон шалгаруулалтаар явуулъя гэж байгаа юм. Саяын ярьж байгаа эрчим хүчний дутагдалтай эх үүсвэрийг нэн яаралтай шийдэх энэ тэр тохиолдлуудад нөгөө худалдан авахын хуульд байгаа нөгөө сонголтот тендертэй адилхан тодорхой тэр салбартаа тэргүүлэх аж ахуйн нэгж байгууллагуудад урилга хүргүүлээд уг ААН-үүдээс ирүүлсэн урилга дээр үндэслэж төр хувийн хэвшлийн түншлэлийн сонгон шалгаруулалтыг хийх аргыг саяын байдлаар тодорхойлж томъёолж оруулж ирсэн. Ингэхдээ бас тодорхой процесс бичсэн гэдгийг хэлье ээ.

Ер нь төр хувийн хэвшлийн түншлэл дээр дийлэнх тохиолдолд одоо дандаа нээлттэй сонгон шалгаруулалт хийе гэж байгаа. Одоо ч тухайлах юм бол бид энэ хууль үйлчилж эхлэх юм бол нийслэлийн.

Ц.Даваасүрэн: Энэ нөгөө нэг төрийн болон орон нутгийн өмч гэхээр Бараа худалдан авах тухай хууль чинь төсвийн хүрээний мэдэгдлээ биш Төсвийн тодотголын хуулиа дагаж өргөн мэдүүлсэн байгаа юм байна лээ шүү. Тэрийг бас та бүхэн анхаараарай.

Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье. Түрүүн тасарч байна лээ. Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Дийлэнх асуултууд давхцаад байна. Тэгээд нэг материал их тулгамдуу тараасан учраас бас тодорхойгүй зүйлүүд байвал тодруулаад өгнө үү? Залруулаарай гэж хүсэх байна.

Нэгдүгээрт энэ 3 намын гэрээг үндэслээд 2024-2028 оны хугацаанд хэрэгжүүлэх бодлого гэж ойлгосон. Энэ зөв үү? Энэ 3 намын нэгдсэн байр суурь гэж ойлгож болох уу гэж асуумаар байна.

Хоёрдугаарт энэ бодлого дээрээ энэ ажлын байр бий болгодог татвар төлдөг субъектүүдийг хэрхэн дэмжих бодлого орж байгаа вэ? Түрүүний Түвшин гишүүний хэлдгээр одоо НӨАТ-ын асуудал НДШ-ийн асуудал орлого тал дээр нэлээн ачаалал болдог. Тэгээд өнгөрсөн хугацаанд ковид тэгээд эдийн засгийн хүнд үеүдэд энэ зээл болон татварын төлөлтийг хойшлуулсан болохоос биш хөнгөлөлт эдлүүлээгүй гэж ойлгож байгаа. Тэрэн дээр ямар бодлого барьж байгаа вэ? Тэгээд төсвийн тэлэлт та бүхэн санаж байгаа бол одоо 2023 онд чинь 22 их наяд байсан одоо ингээд 30 их наяд гээд бараг 30 хувьаар ингээд өсчхөж байгаа юм. Тэгээд урсгал зардлаа 30 хувьд барина л гээд ингээд тавьчихсан байгаа юм.

Тэгэхээр би энэ ДНБ-ий бодох аргачлалыг ажлын хэсгээс цаасаар тусад нь авч болох уу? Дээрээс нь хэрэглээний үнийн өсөлт 6.5 байна гээд энэнтэй би санал нийлэхгүй байгаа юм аа.

Өнөөдөр яг амьдрал дээр бол барааны өргөн хэрэглээний барааны өсөлт маш өндөр хувиар өсөж байгаа. Тэгээд энэнтэй уялдсан одоо бодлого нь мөн юм уу тэгээд энийг бас бодсон аргачлал яаж 6.5 гаргасан юм? ДНБ-ий өсөлтийг 5.6, ирэх онд 8 гэж төсөөлсөн байгаа юм. Энэ бодсон аргачлалыг цаасаар авмаар байна болох уу гэж асуумаар байна. Тэгээд дээрээс нь энэ төрийн байгууллагын одоо хэмнэлтийн асуудлыг яаж бодлогодоо шингээж байгаа юм бэ? Өнөөдөр хагас жилийн хугацаанд төрийн байгууллагуудын дансан дээр байгаа зарагдаагүй зардлуудыг хэрхэн бодлогын түвшинд хянаж байгаа юм. Хэрхэн хэмнэлтийн бодлого хийж байгаа юм энэ тал дээр яг бичгээр бас хариу авмаар байна аа. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Гишүүд тэр нөгөө нэг унших боломж олгохгүй байна гээд байгаа нөгөө ердийн горимоор өргөөгүй яаралтай горимоор өргөчихсөн учраас ийм нэг дэгийн өөрчлөлт 9, 10 оны үед

нөгөө баярын Засгийн газрын үед хийгдчихсэн байхгүй юу. Тэгээд одоо тэр тэр горимоор явж байгаа гэсэн үг. Тэгэхээр нөгөө Дэгийн тухай хууль дээр байгаа ердийн горимоос өөр гэсэн үг шүү. Тэрийг та бүхэн анхаараарай.

Хариулъя. Жавхлан сайдын микрофон 3.

Б.Жавхлан: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя аа. Энэ удаа бид 2024 оны төсөвт хийх тодотгол оруулж ирж байгаа. Удахгүй одоо 9 сарын 1-нд бид Улсын Их Хуралд 2025 оны одоо бүтэн төсөв өргөн барина. Тийм учраас бид тодотголоор одоо тэр бүр бүхий л бодлогыг хамруулах боломжгүй. Ирэх оны төсвийг дагуулж нөгөө татварын бодлогын бас зохих одоо ялангуяа хувийн хэвшлийг дэмжсэн ийм одоо зорилтот бодлогуудыг танилцуулна. Удахгүй танилцуулна. Дотоодын нийт бүтээгдэхүүн болон инфляцыг тооцох аргачлалуудыг бид танд хүргүүлье ээ. Инфляцыг Статистикийн ерөнхий хорооноос гаргадаг. Одоо өөрсдийн аргачлалтай. Тэднийхээс аваад бид танд дамжуулъя. ДНБ-ийг ч гэсэн мөн одоо Монголбанк Статистикын хорооныхон өөрсдийнхөө аргачлалаар гаргадаг. Эндээс бид авч хэрэглэдэг тоо юм байгаа юм. Инфляц яах вэ? Зүгээр нэмж мэдээлэл өгөхөд зүгээр инфляц гэдэг маань сүүлийн нэг жилийн одоо инфляцыг тооцдог 360 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн хөдөлгөөн. Сүүлийн нэг жилийн. Хоёулаа энийг сүүлийн нэг 4, 5 жилийн одоо ковидоос эхэлснээс хойш харах юм үнэхээр юу нь 6.5 битгий хэл зарим нэр төрлийн бараанууд дээр бараг 100 хувь өссөн байгаа. 100 хувь үүссэн. Тэгэхээр энэ инфляцыг бол бид сүүлийн жилийн хөдөлгөөнийг ярьж байгаа буюу өнөөдөр гаргаж байгаа одоо жишээ нь 8 сарын инфляц өнгөрсөн жилийн 8 сараас хойш гарч байгаа 360 бараа бүтээгдэхүүний дундаж үнийн одоо хөдөлгөөн юм аа.

Хэмнэлт гэж байна. Бид ковидын үед одоо хэмнэлтийн хууль гээд мундаг хуультай болсон үе үеийн одоо Сангийн

сайд, Засгийн газар одоо бас л хэрэгтэй хууль гэж олон ч ярьж байсан. Тэр үед одоо боломж гарсан нэлээд бас чанга ийм хэмнэлтийн хууль болсон. Түүхэн үүргээ гүйцэтгэсэн үүргээ гүйцэтгэсэн байгаа. Тийм учраас энэ хуулийг аль болох өөрчлөхгүй ингээд аваад явчихвал их зүгээр байгаа юм. Бид нөгөө хүнд байсныгаа маш амархан мартчихдаг. Одоо энэ хэмнэлтийн хууль маань эргээд одоо төрийн үйл ажиллагааг маш их хязгаарлаж байна. Энэнийхээ зарим зүйл заалтуудыг одоо зөөллөө гэдэг ийм саналууд одоо их цухалзах болсон. Аль болох энийг өөрчлөхгүй аваад явчихвал их сайн байгаа юм. Тэгэхдээ хэмнэнэ гэдэг маань өөрөө их учиртай. Төсвийн зорилго бол төрийн үйл ажиллагааг тасалдуулахгүй бүрэн санхүүжүүлэх үндсэн үүрэг нь хэмнэлтийн цаана одоо хэт их хэмнэх одоо сохроор одоо хэмнэх юм бол төрийн үйл ажиллагаа өөрөө тасалдах бас өндөр эрсдэлтэй.

Тэгэхээр төрийн одоо суурь үйл ажиллагаанууд маань ямар ч тасралтгүй ялангуяа одоо нийгмийн чиглэлтэй тийм ээ, боловсрол, эрүүл мэнд одоо хөдөлмөр хамгаалал, нийгэм хамгааллын гээд эдгээр үйл ажиллагаанууд тасалдахгүй явах ёстой. Үүнийг одоо бүрэн санхүүжүүлнэ. Энэнээс цааш гарч байгаа зүйлүүдийг одоо бид бас хэмнэлт гэж харах хэрэгтэй байгаа юм тийм. Ямар ч байсан одоо 8 сарын гүйцэтгэлээрээ бид урсгал зардал хэвийн явж байгаа. Даваагүй гүйцэтгэл бол нэг 80 гаран хувьтай ингээд явж байна.

Ц.Даваасүрэн: Тодруул тодруул Пүрэвдаваа гишүүн.

Д.Пүрэвдаваа: Энэ 3 намын гэрээ гээд тэгээд энэ одоо 24-28, 4 жилийн бодлого гээд энэ дээр л байна л даа. Тэгээд энэ 3 намын нэгдсэн байр суурь мөн үү л гэж асууж байгаа юм.

Ц.Даваасүрэн: Жавхлан сайд 3 намын микрофон хариулъя.

Б.Жавхлан: Өнгөрсөн 1 дэх өдөр шинэ парламентад шинэ парламент сонгуулийн үр дүнд бий болсон одоо 3 намын төлөөлөл 3 намын одоо ажлын хэсгүүд гараад гэрээ хөтөлбөр дээрээ хамтарч суугаад гэрээгээ бол одоо үзэглэсэн. Хөтөлбөрөө мөн одоо энэ дээр санал нэгдээд өргөн барьсан байгаа.

Ц.Даваасүрэн: Батболд гишүүн асуултаа асууя.

Р.Батболд: Өдрийн мэнд хүргэе. Энэ урд талын асуулт асуусан гишүүд бас давхцаад байна. Тэгэхээр яах вэ би дахиад асуучихъя. Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн өөрчлөлттэй холбоотой энэ нэгдсэн төсвийн суурь зарлага хэмээх ойлголтыг оруулаад тэгээд тэнцлийг тооцохдоо үнэт цаас болон гадаадын зээлээр санхүүжих зардлыг оруулахгүй гээд байгаа юм. Тэгэхээр энэ чинь ер нь төсвийн сахилга батаа алдчих юм биш үү гэдэг нэг эмзэглэл байгаа. Тэгээд баахан зээлээр санхүүжүүлсэн зардлуудаа бүгдийг нь зардалд оруулахгүй тооцоод яваад байдаг. Тэгээд энэ нь ер нь цаашидаа яваад макро эдийн засгийн түвшиндээ бас эрсдэл үүсгэх юм биш үү гэдэг нэг асуулт.

Хоёрдугаарт нь гэх юм одоо энэ зардал тооцохгүй яваад байхаар нөгөө бүртгэлийн асуудал гэж бас энэ бүртгэл нь яаж явах юм бэ гэдэг. Тэгээд тэнцэл нь бас л ийм 2 бүртгэлтэй л явах гээд байна уу гэдэг л нэг асуудал байгаад байна. Тэгээд дараагийнх нь 3 дугаар асуудал нь нэгдсэн төсвийн урсгал зардлыг ДНБ-ий 30 хувиас хэтрүүлэхгүй гээд байгаа юм. Тэгэхээр 2024 оны төсвийн зардлын төсөөлөлдөө болохоор 22.4 их наядаар төсөвлөж байсан. Төсвийн хүрээний мэдэгдлээрээ 27.4 их наяд гээд, 5 их наядаар нэмэгдчихсэн. Өнөөдрийн төсвийн тодотголоор дахиад 3.1 их наядаар нэмээд ингээд 30.5 их наяд болчихоод байдаг. Энэ чинь одоо явсаар байгаад бүр ДНБ-ийхээ 37хувь руу орчихоод байгаа юм. Нөгөө 30 хувьд барья гэдэг юм чинь алдагдаад байна л даа.

Ц.Даваасүрэн: 2 асуултад хариулъя. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Батболд гишүүний асуултад хариулъя.

Бүртгэлийн хувьд ямар ч өөрчлөлт гарахгүй. Тооцоолох энэ аргачлал дээр л бид өөрчлөлт орж ирж байна гэсэн үг юм байгаа юм. Тэгээд бүртгэлд ямар ч өөрчлөлт гарахгүй. Өрийн хувьд энд одоо тэнцэл алдагдаад эрсдэл нэмэгдэх юм биш үү гэж байгаа юм. Харин ч уг нь эсрэгээрээ юм байгаа юм. Сайн энийгээ одоо бас хугацаа нэлээн давчуу үзэж амжихгүй байх шиг байна гишүүд маань. Ер нь ийм юм байгаа юм. Энэ 4 жилийн хугацаанд бидэнд одоо маш том боломж одоо бий болж байна. Өөрөөр хэлбэл ард түмний сонголт энэ одоо Засгийн газар хамтраад энэ одоо олон гацаанаасаа гараад ингэж хөгжлийнхөө зөв замд энэ зам бүтээн байгуулалт энэ хөрөнгө оруулалтууд ялангуяа дэд бүтцийн чиглэлийн. Тэрнээс биш бид нар одоо төр өөрөө ашигийн төлөө биш харин ашиг олдог баялаг бүтээ гэдэг хувийн хэвшлийг дэмжих энэ бүтээн байгуулалт дэд бүтцүүдээ нэг хийгээд аваач гэдэг ийм боломж чөлөө өгч байна гэж ингэж ойлгож байгаа.

Хамтарсан Засгийн газрын гэрээ, хурдтай хөгжлийн төлөө одоо зориг энэ хөтөлбөрүүд маань одоо томоохон бүтээн байгуулалт ялангуяа дэд бүтэц рүүгээ чиглэсэн шүү. 120 гаруй их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтууд шаардагдаж байгаа. Энийг бүгдийг нь одоо төсөв хийгээд яагаад ч дийлэхгүй.

Тийм учраас төсөв өөрөө дийлэх хэмжээндээ бид эдийн засгийн дэмжлэг үзүүлээд явахад гарцаагүй бид ийм өөрчлөлт хийхгүй бол бид юу ч хийж амжихгүй. Юу ч хийж амжихгүй. Тооцоолох аргачлал дотор хэдийгээр одоо энэ хөрөнгө оруулалтын хязгаар гэж яриад байх юм. Хөрөнгө оруулалтын хязгаар гэдэг ойлголт байхгүй шүү.

Хөрөнгө оруулалтууд дээр одоо гадаад зээл тусламжаар санхүүжиж байгаа зардал тэр зардал байхгүй юу. Энийг аргачлалаараа тооцохдоо бид одоо суурь зардал 30 хувь, дээрээс нь энд одоо 2 хязгаар байгаа. Бид нар одоо 3, 3 жилээр одоо батлагддаг өрийн удирдлагын одоо дунд хугацааны стратеги энэ дээрээ нэг хязгаарлана.

Дээрээс нь өрийн дээд хязгаар тааз гээд 60 хувь гээд заачихсан байж байгаа. Ийм хязгаарууд дотроо үйл ажиллагаагаа явуулаад эдгээр одоо шаардлагатай хөрөнгө оруулалтуудаа хийгээд явна. Дээрээс нь урсгал зардал одоо урсгал тэнцэл маань жил бүр 2-оос доошгүй ашигтай гаргах ёстой гэж байгаа юм. Энэ 2 хувийг одоо байнга одоо төсвийн алддаг нэг нийт тэнцлийг бууруулахад одоо том өр зээл тухайн жилийнхээ одоо бондын төлбөр үндсэн одоо зээлийн төлбөрүүдээ хийхэд ашиглаад явах юм байгаа юм. Тэгэхээр одоо байгаа тэнцлийнхээ ер нь нэг ийм баримжаа тоогоор 2 хувийн ашиг гэдэг маань нэг 500-аас дээш тэрбумын байнгын ашигтай гарна. Энүүгээр бол жил бүр одоо цаашидаа энэ 30 он хүртэл жил бүр бид нар төлөх гадаад өрөө бүрэн төлөөд явах ийм боломжтой болж ирж байгаа юм.

Тэгэхээр өрийн удирдлага тал дээрээ бид одоо улам сайжирна л гэсэн үг.

Ц.Даваасүрэн: Батбаяр гишүүн асуултаа асууя.

Д.Батбаяр: Нэлээн хэдэн юмнууд нь давхчихаж байгаа учраас татаад авчихъя. Асуулт алга.

Ц.Даваасүрэн: Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн байвал кнопоо даръя. Картгүй юм уу, уншуулахгүй байгаа юм уу? Эрдэнэбат гишүүн. Энэ харьяалалгүй гишүүд оролцож болно шүү дээ. Энийг Тамгын газар зохицуулах хэрэгтэй шүү. Хэн ч орж ирж асуулт асууж үг хэлж болно. Зөвхөн санал хураалтад

оролцохгүй ийм дэгтэй шүү дээ. Ингээд Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүний юуг нэмээд оруулчихъя. Тэгээд микрофон нээж өгөх хэрэгтэй болох нь байна. Тэрийгээ манайхан одоо зохицуулаадах. Чойжилсүрэн гишүүн үг хэлье.

Б.Чойжилсүрэн: Төсвийн байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амрыг эрье ээ. Энэ удаагийн төсвийн тодотгол орж ирж байгаа энэ тодотгол дээр төсвийн тэнцвэржүүлсэн зардал 3 их наядаар нэмэгдэж байгаа. Гэхдээ энэ их 3 их наядын 1 их наяд орчим нь гадаад зээлийн ашиглалт эх үүсвэртэй зардал, 1 их наяд орчим нь Улаанбаатар хотын бондтой учраас ерөнхийдөө би хэсэгтээ ойлгохдоо төсвийн орлого маань 2024 оны одоо батлагдсан байгаа юунаас нэг 1 их наяд орчмоор нэмэгдээд тэнцэл маань ерөөсөө өөрчлөгдөхгүй юм байна гэж 1 дүгээрт ийм ойлголттой байгаа гишүүддээ.

Хоёрдугаарт олон гишүүд сая ярьж байна. Энэ суурь зардал гэдэг ойлголтыг оруулж ирснээр зээлийн өр хэмжээ нэмэгдчих юм биш биз гэсэн ийм болгоомжлол байгаа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 4 хязгаарлалт бий. Одоо өрийн дээд хязгаар энэ 60 хувиа бид нар нэг өөрчлөхгүй бол өр бол энэ хязгаараас дээшээ явахгүй. Та бүхэн энэ өр дээр санаа тавьж байгаа улсууд энэ хязгаарыг одоо 65, 70 болгоод эхлэх юм бол өр нэмэгдүүлэх гэж байна гэдэг ийм хардлагад орно.

Хоёрдугаарт, сая Сангийн сайд ярьж байна шүү дээ. Чи 20 жилийн дараа төлөх 1 сая төгрөг, маргааш төлөх 1 сая төгрөг 2 үнэ цэн нь өөр. Өнөөгийн үнэ цэнээр бодож явж байсан ОУВС, олон улсын санхүүгийн байгууллагууд энийг бол ерөнхийдөө дургүй боловчиг зөвшөөрөөд явж байсан. Сангийн сайд бол энэ олон улсын санхүүгийн зах зээл рүү оруулаад номинал буюу нэрлэсэн дүнгээр бодохоор Засгийн газрын үнэ, ДНБ-ий 4 орчим бараг 5 орчим хувиар нэмэгдэж байгаа юм 39. Одоо өнөөгийн үнэ цэнээр бодох юм бол 39

хувьтай байгаа нь нэрлэсэн дүнгээр бодохоор одоо 44, 45 орчим хувь болчихож байгаа учраас энэ өр нэмэгдүүлэх өрийн дарамтад орох болов уу гэсэн энэ зовнил бол харьцангуй гайгүй ийм байгаа. Одоо Засгийн газар байгуулагдаад хамтарсан Засгийн газар байгуулагдсан тодорхой хэмжээний жоохон ажил хийх шаардлагатай үүссэн 120 орчим тэрбум төгрөгийн Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр оруулаад ирчихсэн байгаа учраас гишүүд минь энэ дээр бас наанатай цаанатай хандаад зөв ойлгоод энэ төсвийн төсөл тэр тодотголыг дэмжиж өгөөч. Энэ удаа бол хэлэлцэх эсэхийг нь шийдчихээд юу чуулганаар оруулж ирээд анхны хэлэлцүүлэг рүү авахаараа ажлын хэсэг байгуулагдах байх. Тэр үедээ бол Сангийн яам болон Засгийн газар шаардлагатай мэдээллүүдийг нэмж өгье.

Ингээд дэмжээ ч гэсэн ийм хүсэлт байна.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Баярлалаа. Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Төсвийн хүрээний мэдэгдэл төсөөллийг дэмжчихье гэсэн бодолтой байна. Хэлэлцүүлгийн түвшинд ажлын хэсэг дээр нэлээн сайн харна биз дээ? Энүүгээр бид нэг их учиргүй өрөнд орчих юм ч гэж байхгүй л дээ. Ерөөсөө ойрын 4 жилд нэг 10.5 их наяд, яг бол одоогийн үнэ цэнээрээ. Тийм хэмжээний зээл аваад хөрөнгө оруулалтаа хийчихье л гэсэн санаа байхгүй юу. Энэ олон юм чинь угаасаа өрийн хууль, тогтвортой байдлын хууль энэ бүх юмаараа бүгд хайрцаглагддаг. Ганцхан нэршил солиод байгаа нь юу вэ гэхээр зэрэг тухайн жилд орлого зарлага 2-ын хоорондын бүтэц нь 10.5-аар өсөж болохгүй байгаа учраас л энүүн дээр гаргалгаа хийгээд байна шүү дээ. Одоо нэрлэсэн үнэ рүү шилжүүлэхээр ДНБ-ий 45, 60 байж болох хуулийн дээд таазтай 15 хувиа авъя гэж байна. 74 их

их наядын ДНБ-тэй бид энэ чинь 10.5 их наядын л зээлийн одоо нэмэлт багтаамж өнөөдрийн байдлаар бол. Тэгэхдээ мэдээж энэ бол тогтвортой үзүүлэлт биш. ДНБ жил болгон 6-аас 8 хувийн өсөлт авдаг гэж үзэх бол жил болгон бараг 5 их наядаар өсөж байгаа. Тэрнээс дахиад өсөлт авах боломж бий. Тэгэхээр энийг харахаар зэрэг өрөнд орчихно ч гэж би харахгүй байна. Гэхдээ гадаадын зээл ашиглаж байгаа тохиолдолд хэлцэл бүх юмнууд нь Их Хурал дээр орж ирж батлагдаж байгаа.

Тэгэхээр ирээдүйд үнэ цэн авчирч өгөх тийм төслүүдээ дэмжих хэлбэр лүүгээ л Их Хурал анхаарлаа хандуулаад ажиллах юм бол нэг чих айхтар хүндэрчих нь ч хаашаа юм зүгээр. Ер нь бол гаргалгаа нь энэ л юм билээ. Энийг өчигдрөөс хойш бас уншаад зарим тохиолдолд сайдтайгаа ам зөрөх нь холгүй байгаад ингээд уншаад байгаа юм. Тэгэхээр ингэхээр нэг ийм үзүүлэлт харагдаж байгаа. Ямар ч байсан ажлын хэсгийн түвшинд нь нэлээн нэг сайн нухацтай уншаад мэргэжлийн хүмүүсийнхээ санаа бодлыг аваад тэгээд ойлголтоо жигдлээд дундын хувилбараараа гаргахад би нэг их буруудах юмгүй юм байна л гэж ингэж л харж байна шүү дээ.

Тийм учраас дэмждэг юм уу л гэж байна.

Ц.Даваасүрэн: Түвшин гишүүн.

Б.Түвшин: Тэгэхээр яах вэ ер нь бол Засгийн газарт хөрөнгө оруулах төсөв зардлуудаа өөрчлөх, тодотголоо хийх, тэгээд энэ хамтарснаар нэлээн өөрчлөлтүүд хийх боломж нь байж л байгаа шүү дээ. Яаралтай гэдэг горимоор оруулж ирээд бараг унших боломжгүй тохиолдолд Засгийн газар нь өөрөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг өөрчлөөд оруулж ирэх асуудал чинь өөрөө тэгвэл Төсвийн тогтвортой байдлын хуулиар яах юм бэ? Тэгээд яаралтай л өөрчилчихдөг юм бол. Энэ хуулийг өөрчлөхгүй. Тэр харилцаа,

харьцаа, нэр томъёонуудыг байгаагаар нь байлгаж байгаад тэгээд тэр одоо ДНБ-ий өр нь одоо 30-аас тэр тооцоолоод 45 хүрдэг юм бол 45-аас 60 хүргэх эрх мэдэл нь байж байгаа юм чинь тэр өөрсдийнхөө эрх мэдлийн хүрээнд тодотголоо оруулж ирвэл яасан юм. Хууль өөрчлөөд, хууль хуульдаа яг одоо энийг чинь ингээд эрх зүйн талаас нь авч үзэх юм бол төсөв оруулж ирж байгаа хүмүүс нь яаралтай горимоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа өөрчлүүлээд хэдхэн хоногийн дотор батлуулах гэж байгаа нь ашиг сонирхол гэж харагдана шүү дээ.

Тийм учраас энэ хүрээндээ бол өөрчлөлтүүдээ хийгээд дээрээс нь тэр зардлаа хасаад зарим нэг одоо хасаж чаддаггүй байсан зардлуудаа хасаад хэрэгтэй зүйлүүдээ оруулаад ингээд хийвэл энэ болж байгаа юм биш үү. Тийм учраас миний хувийн санал бол Төсвийн тогтвортой байдлын хуулийг өөрчлөхгүйгээр дээрээс нь одоо байгаа тэр дүрэм журам харьцаануудаа нэр томъёо өөрчлөх замаар чөлөөлөхгүйгээр тэр хүрээндээ бүх өөрчлөлтүүдээ хийгээд оруулж ирвэл харин тодотгол хийх боломжтой эрх мэдэл нь байгаа л гэж ойлгож байна.

Ц.Даваасүрэн: Пүрэвдаваа гишүүн үг хэлье.

Д.Пүрэвдаваа: Юу яаж байна даа 2024-2028 он гэдэг тоонууд яваад байгаа юм. Тэгээд энэ үг өгүүлбэр дээр нь болохоор энэ шинэ 30 жилийн бодлого гээд байгаа юм. Тэгэхээр энэ ингээд материалтай гүйлгээд танилцахаар зэрэг ерөнхийдөө ийм тайлбарласан байдалтай. Тэгээд бодсон аргачлалыг ажлын хэсгээс авмаар байна. Тэгээд дээрээс нь аудитын газраас энэ бодсон аргачлал дээр хийсэн дүгнэлтийг авмаар байна. Тийм боломж байгаа юу гэдгийг одоо уламжилмаар байна. Тэгээд та бүхэн маань энийг ялангуяа яаравчилсан байдлаар түргэвчилсэн байдлаар шийдэж байгаа учраас энэ хуульд өөрчлөлт оруулж байгаа бол эдийн засгийн болон санхүүгийн үр өгөөжийг яаж харж

байгаа юм? Ямар аргачлалаар хийгдэж байгаа талаараа одоо энэ бусад энэ том намууд бол намын бүлгээрээ олон цаг хуралдаад шийдчихэж байгаа байх. Манай эвсэл бол одоо бүлэггүй учраас мэдээлэл авах ижил тэнцүү мэдээлэл авах боломж байхгүй байна.

Тийм учраас та бүхнээс цаасаар яаралтай эдгээр мэдээллүүдийг авъя гэж хэлэх байна.

Ц.Даваасүрэн: Тэр мэдээллийг нь Пүрэвдаваа гишүүн та нар гаргаж өгөөрэй. Ажлын хэсэг. Ганхуяг гишүүн үг хэлье.

Х.Ганхуяг: Үндсэндээ сарын дараа 2025 оны төсвийг бид нар бас одоо Засгийн газар өргөн барих байх. Тийм төсвийн төсөөлөл бол нэлээн өөдрөг байдалтай харагдаж байна. Яах вэ миний хувьд бол шинжээчдийн хувьд ирэх 2025 он, 2026 он нэлээн ойлгомжгүй байдалтай байгаа эсрэгээрээ. Тэгээд яг өөдрөг байдлаар ингээд явчихдаг. Бид нар байнгын өөдрөг байдлаар зарлагаа бас дагаад л өсгөөд л яваад байх нь бас хэр зохимжтой байх. Яах вэ мэдээж хэрэг Засгийн газар бол одоо бүрэлдээд эхний нэг сар энэ эхний нэг жилдээ багтаагаад ажлуудаа бас нэлээн явуулчих нь зөв. Тэгээд саяын ярьж байгаа тэр төсвийн хөрөнгө оруулалтуудыг дэмжиж байна. Гэхдээ 2025 оных нь төсөв дээр бас нэг жоохон анхааралтай ажиглахыг хүсье. Дагалдах хуулиуд яах вэ тэгээд ажлын хэсэг дээр л ярилцаад явъя даа. Одоо тэгэхгүй бол ёстой нөгөө нуухыг нь авах гэж байгаад нүдийг нь сохолно гэгчээр одоо нэг орон нутагт эрх мэдлийг нь өгч байгаа гээд орон нутгийн өмчит компани бид нар нөгөө төрийн болон орон нутгийн өмчийн компанийнхаа хуулиа шинэчилж чадаагүй хуучнаараа явж байгаа засаглал нь муу. Өнгөрсөн хугацааны бүх хулгайч нь дандаа л орон нутгийн одоо нөгөө төрийн болон орон нутгийн өмчийн компани дээр явагдсан байдаг.

Тэгээд тэр төрийн худалдан авах тэр хуулиуд дээр бол ажлын хэсэг нэлээн

сайн анхааралтай ажиллах ёстой болов уу гэж бодож байна. Тэгэхгүй бол ингээд дарга нь өөрийнхөө мэдлийн орон нутгийн өмчит компанидаа тэр асуудлыг нөгөө тендер шалгарсангүй гээд л ажил өгөөд л яваад байх нь өөрөө эргээд авлигын асуудал ч болно. Мөн хувийн хэвилийн эсрэг одоо хувийн хэвилийн оролцоог дэмжихгүй байхаар, дэмжигдэхээргүй байхаар харагдаад байна л даа. Тэгээд нөгөө компани нь алдагдалтай ажилладаг алдагдлыг нь төсвөөс юм уу орон нутгийн төсвөөс нөхөж өгдөг нэг ийм нэг ийм мөнгө угаадаг ийм механизм болчих вий дээ. Тэгээд энэ дээр бол нэлээн анхааралтай бас та бүхнийг ажиллахыг бас хүсэж байна аа? Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Дэгээрээ явна одоо Эрдэнэбат гишүүн тэгээд болчихсон. Эрдэнэбат гишүүний микрофоныг өгье. Зүүн талаасаа 8 дахь микрофоныг өгөх гээд үз дээ техникийнхэн. Цогтбаатар гишүүний микрофоныг өгөх гээд үз дээ. Кнопоо дар.

С.Эрдэнэбат: Ингэхийгээд ярьчих уу? Товчхон нэг 2, 3 санал хэлье. Түрүүн бас асуулт санал дээр олон санал давхацсан учраас төсвийн тодотгол дээр орж ирж байгаа ер нь удахгүй тэр сарын дараа ч гэсэн одоо ирэх онуудын төсөв төсвийн хүрээний мэдэгдэл одоо төсөөллүүд явж эхэлнэ. Тэгэхээр энэ төсөв томоохон эдийн засгийн одоо төсөл хөтөлбөрүүд дээр нэг нийгмийн үнэлгээ гэдэг нэг зүйлийг хиймээр байгаа юм аа. Энэ төслүүд чинь өөрөө дан болон шууд үр ашиг хүртэгч нар хэчнээн жижиг дунд, аж ахуйн нэгж байгууллагууд, ажилтан, сайн ажлын байрууд бий болох юм гэдэг юм уу ийм үнэлгээг хийж явахгүйгээр ерөнхийдөө одоо томоохон төсөл гэдэг нэрийдлээр нь ингээд яваад байхаар нийгэм, эдийн засгийн энэ хүртээмжтэй өсөлт гэдэг энэ олон улсад одоо хэрэглэгдэж байгаа энэ үнийг үнэлдэг мөн олон улсын санхүүгийн байгууллагуудын хямд бөгөөд одоо найдвартай бас тийм эх үүсвэрүүд ч гэсэн энийг хардаг болчихсон. Манай банкнууд ч гэсэн одоо олон улсын төсөв

санхүүжилтийг оруулж ирэхдээ энийг бас давхар хардаг болчихсон байна лээ.

Тэгэхээр бид нар энэ маш том одоо төсөв мөнгөн дүнтэй зүйл ярьдаг. Тэгэхээр энийг одоо энэ төсвийн хууль дээр төсвийг танилцуулахдаа ийм нэг үнэлгээ хийдэг одоо түр хороо гэдэг юм уу ийм зүйлийг нэг авч үзмээр байна гэдгийг би хэлмээр байгаа юм.

Дээрээс нь энэ том том төсөл хөрөнгө оруулалт чинь нөгөө талдаа бас нэг зүйл дагуулах гээд байдаг юм. Нөгөө бидний ард иргэдийн хамгийн хүсэн хүлээдэг нийгмийн шинж чанартай зардлууд чинь нөгөө цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн хамгааллын асуудлууд, боловсрол, эрүүл мэндийн зардлууд чинь эх үүсвэр байхгүй болчих гээд байгаа бас эрсдэлтэй байдаг. Үүнийгээ бас яах вэ давхар бас тооцсон байлгүй гэж би бас бодож байна. Томоохон бас тэр төсөл хөтөлбөрүүдийн хувьд явуулах ажлууд бол өчигдөр бас яригдсан учраас энэ дээр одоо санал хэлэхгүй дэмжиж байна. Цаашидаа энэ хэмнэлтийн хууль дээр түрүүн Жавхлан сайд бас хэллээ аудитынхан бас байж байна. Энэ нэлээн чанга хууль байгаа. Цаанаа аягүй олон нүдэнд харагдахгүй ч гэсэн сөрөг үр дагавар дагуулж байгаа маш олон санал гомдлууд байдаг. Тэгээд энэ чиглэлээр би бас тодорхой саналуудыг бас хүргүүлсэн. Тэгээд энэ талаар дараа товч мэдээлэл би авъя. Тэгээд энэ төсвийнхөө ирээдүйн ачаалал энэ нь өөрөө эргээд Үндэсний аюулгүй байдалд бас нөлөөлөх энэ тэр гэдэг энэ зүйл дээр бид нар дээр бас тодорхой нарийвчилсан мэдээллүүдийг бол төсвийн хэлэлцүүлгийн явцад болон наана нь авъя гэж бодож байна аа. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Гишүүд үг хэлж дууслаа. Би нэг товчхон бас төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөлтэй холбогдуулаад бас саналаа хэлчихье.

Тэгэхээр гишүүдийн зардал дээр одоо бас анхааралтай байя хяная гээд байгаагаар би санал нэг байгаа юм.

Мэдээж хэрэг одоо Засгийн газар тэгээд хамтарсан Засгийн газар байгуулагдаад бас томоохон ажлууд хийе гэсэн ийм төлөвлөлт байна. Хийх ёстой ажлууд зөндөө байна. Эрчим хүчний асуудал байна ялангуяа. Эрчим хүчний эх үүсвэрийн дутагдалд орсон хэрэглээ нь одоо бүүр даваад явчихсан гэх мэтийн асуудлууд байгааг бид ойлгож байгаа. Гэхдээ зардлаа хянах чиглэлд анхаарахгүй бол 2023 онд 12 их наяд байсан зардал маань 2024 онд 2 дахин нэмэгдэж 24 болсон. Одоо 30 болох гээд явж байна шүү дээ.

Тэгэхээр энд ямар эрсдэл байна гэвэл манай өөрөө орлого 80 хувь уул уурхайгаас хамааралтай тэрэн дотроо ганц нүүрснээс хамааралтай. Тэгэхээр нүүрс дээр ямар нэг асуудал үүслээ гэхэд бид нар шоконд орох гээд байгаа байхгүй юу. Хэтэрхий зардлаа өсгөөд явах юм төсвөө тэлээд яваад байх юм бол маш том шоконд орно. Тэр их хэмжээний мөнгийг бид нар нөхөж чадахгүй болно. Тэгэхээр ганц нүүрсэнд амьдралаа даатгаад явах уу гэдэг асуудал дээр бид нар бас бодолтой байя гэж байгаагаар би санал нэг байгаа юм. Тэгээд энэ төсвийн тэр суурь тэнцэл, суурь зарлага гээд байгаа асуудлуудыг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцэж байна уу гэдэг асуудлуудыг хэдүүлээ бас эргэж харъя. Хэлэлцэх эсэхээ дэмжээд явъя. Төсвийнхөө үзүүлэлтүүдийн баланс дээр бол эргэж төлөгдөх цэвэр зээл, эх үүсвэр талдаа зээлүүд та нарын яриад байгаа үнэт цаас шинээр авах зээл бүгд байгаа.

Гэхдээ төсвийн хүрээний мэдээллийн шалгуур үзүүлэлт дээр одоо ийм суурь тэнцэл гэж юм орж ирж ингээд байгааг ер нь байх ёстой юу үгүй юү гэж? Ер нь 1 юмыг бид нар бодох ёстой. Нэг нь тогтвортой байлгая гэсэн юм бол энийгээ дагаж мөрдөх ёстой. Энэ чинь уг нь 4-ний 3-аар өөрчилдөг хуультай байсныг Үндсэн хуулийн цэц байхгүй болгочихсон байхгүй юу.

Тийм учраас энэ тогтвортой байдлын тухай хууль энэ төсвийн хүрээний мэдэгдлүүдийг байнгын өөрчилдөг болчихсон. Энэ бол сайн зүйл биш. Бид зарчмаараа явахгүй байна гэсэн үг байхгүй юу. Дүрмээрээ тоглохоо больчихсон л гэсэн үг. Яг сонгодог парламентын зарчмаасаа бид нар ухарчихсан уу ухарчихсан. Яагаад гэвэл хамтарчихсан. Сөрөг хүчин байхгүй болчихсон, хяналт байхгүй болчихсон.

Тийм учраас гишүүдийн өр зээл дээрээ хяналт тавьж явъя гэдэг дээр би санал нэг байна. Чойжилсүрэн гишүүний хэлээд байгаа бас үнэн. Яах вэ бид нар нэрлэсэн үнээрээ болгосон ч гэлээ гэсэн ДНБ-д харьцуулсан өрийн хэмжээ 60хувь гэдэг үзүүлэлт маань бий. Энүүгээрээ одоо өрөө хянаад явах боломж нь байгаа. Тэгэхээр ажлын хэсэг байгуулна өнөөдөр та нар надад бас ажлын хэсгийн нэрийг дахиад өгчих. Нэрээ өгчхөөрэй. Тэгээд ажлын хэсэг дээрээ хэдүүлээ сайн ярья. Ер нь зүгээр дүрмээ нэг их өөрчлөөд байх сайн зүйл биш шүү. Хамтраад одоо хамтарсны гол бидний зорилго бол одоо энэ улс орны шийдэж чадахгүй байгаа юмаа л шийдэх асуудал шүү дээ. Тэг л гэж хамтарсан учраас бас энийгээ бодъё. Тэгээд дүрмээ дагахыг бодъё. Тэгээд эдний одоо дундуур л хэдүүлээ ямар нэг шийдэл гаргаад ингээд ажиллахгүй бол төсвийн хүрээний мэдэгдлээ дөнгөж хэдхэн сарын өмнө баталсан төсвийн хуулийнхаа өөрчлөлтүүдийг шууд өөрчилнө гээд байх нь бас хэцүү л байх. Тэр ялангуяа бүртгэлтэй холбогдолтой яригдаад байгаа юмнуудыг бас манай аудитынхан бас нэлээн дэлгэрэнгүй тайлбартай маргааши аудитын дүгнэлт, төсвийн тодотгол хэсэгт орж ирнэ. Тэгэхэд бас оруулсан байхыг би хүсээж байна.

Ингээд төсвийн хүрээ 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцээд явъя. Тэгээд одоо хэлэлцүүлгийн явцад хэдүүлээ саяын хэлсэн юмнуудаа засаад явъя.

Тэгээд хэлэлцэхийг дэмжье гэдэг саналын томъёололтой санал хураалт явуулъя.

Эхнийх туршилт болгоё уначхаж байна.

Түвшингийнх буруу гарсан, Пүрэвдаваагийнх буруу гарсан байна. Тэгэхээр одоо харин анхааралтай хандана шүү. Уг нь бол бүрэн дэмжигдэхээр гишүүдийн ирцтэй байгаа юм байна шүү дээ. Манай техникийнхэн бас жоохон зөвлөчих. Саяын кноп нь эсрэг гарсан гишүүдэд жоохон зөвлөөдөх дөө санал өгөх дээр нь. Хурууныхаа хээг уншуулна тийм ээ. Тэгээд зөвшөөрсөн татгалзсан гэж гарч ирэхээр зөвшөөрснийг дарна. Бэлэн үү айн?

2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026-ны төсвийн төсөөллийг хэлэлцэхийг дэмжье.

21 гишүүнээс 13 гишүүн дэмжиж 61.9 хувиар хэлэлцэхээр дэмжсэн байна. Пүрэвдаваа гишүүн энэ дээр нэмэгдье гэж байгаа юм байна тийм үү? Тэгэхээр татгалзсанаар орно шүү дээ. Тэгээд татгалзсанаар гарна тэгнэ тэгнэ. Тэгнэ санал өгөхгүй, татгалзсан дээр гарна.

Ингээд дэмжигдсэн байна. Чуулганы нэгдсэн хуралдаанд, уучлаарай энэ чинь ингээд явах юм байна. Хууль нэг бүрээр явах юм байна шүү.

Дагасан хуулиудыг бас хураах юм байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөлөл хуваарилах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Энэ техникийн асуудал үүсэж байна. Манай техникийнхэн дүн гарахгүй байна шүү дээ. 0 гээд л зогсчхож байна

шүү дээ. Техникийнхэн хасъя. Энэ ч бас гагцхисан уу? Тэгэхээр чинь одоо гараар санал хурааа гээд горимын санал гаргаад тэгээд гараараа яваад байж болно биз дээ.

Тэгвэл би горимын санал гаргачихъя. Дагаж өргөн мэдүүлсэн хуулиудын хэлэлцэх эсэхийг дэмжих асуудлыг техникийн хүндрэл гарсан учраас гар өргөж санал хурааа гэсэн.

Нэг туршилтын нэг санал хураалт хийгээд үзье. Харин тийм байна. Ингээд нэг дахиад туршилтынхаар явуулъя. Тэгвэл дахиад санал хураалт явуулъя. Байдгаараа л хашираад байна шүү дээ. Бас болохгүй л байна шүү дээ айн. Больё ерөөсөө гар өргөө. Тэгээд гар өргөхдөө байхгүй байгаа гишүүдээ татгалзсанаар тоолоод явчихна за юу. Одоо 21 гишүүн нэрсээс тооцно шүү. Анхааралтай байгаарай. Үлдсэн санал хураалтыг гараар санал хураалт явуулъя. Үүнийг дэмжиж байгаа гишүүн, горимын саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөө.

21-ээс 11 дэмжигдсэн байна. Хөөш анхаарахгүй бол 21-ээс арван нэгхэн хүн байгаа юм байна шүү. 10 болох юм унах юм байна шүү дээ. Анхаараарай.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг дагаж өргөн мэдүүлчихсэн төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор гараар санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү? Хөө дэмжихгүй байгаа юм уу? Үгүй тэгэхээр чинь уначихна шүү дээ. Харин тэгээд байгаа юм. Ялгаа байхгүй үгүй ялгаа байхгүй. Хэд болсон 7 гэхээр чинь уначхаад байна шүү дээ. Хөөш гишүүд ээ, хэлэлцэхийг нь дэмжихээд засах асуудал дээр нь хэдүүлээ ярилцаад явчихвал яасан юм бэ? Нэг онцлог бий. Энэ яаралтайгаар

өргөн мэдүүлсэн. Энэ 2 дахь өдөр, ирэх 2 дахь өдөр дуусах ёстой. Ямар ч хугацаа байхгүй шүү одоо. Би энийг байна шүү дээ. Дахиж хуралдуулах ямар ч боломж байхгүй. Айн тэгээд хэдүүлээ хэлэлцүүлэг дээрээ тэр нэг энэ зарчмын юман дээрээ дүрэм дээрээ өөрчлөлт ороод байгаа юмнуудаа хэдүүлээ гарц хайя аа. Тэгвэл саяын нэг нь санал гарга.

Ганхуяг санал гаргачих.

Х.Ганхуяг: Сая санал хураахад гараа өргөж амжсангүй. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүйд тооцоод дахиад санал хураалт явуулъя аа.

Ц.Даваасүрэн: Ганхуяг гишүүн саяын саналыг хүчингүйд тооцож өгөөч гэсэн горимын санал гаргаж байна.

Гишүүд хэлэлцэхээ дэмжихээд асуудлаа шийдэхгүй бол ямар ч хугацаа байхгүй байгаа гэдгийг анхаараарай. Ингээд Ганхуяг гишүүний гаргасан саяын саналыг хүчингүй болгоё гэсэн горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаад шууд гараа өргөнө үү? 21-ээс 11 дэмжигдлээ. Ирцэд орсноороо тийм тэгээд хүрч байгаа байхгүй юу. 21-ээс 11 чинь хүрч байна хүрч байна. Сая хүрсэн.

Дараагийнхыг нь анхаараарай. 21-ээс 11 болсон. Хүчингүй болгох горимын санал дэмжигдсэн одоо энийгээ хураа хур энийгээ хураагаагүй байгаа хураагаагүй шүү дээ Ганхуяг гишүүн.

Ганхуяг гишүүний горимын санал дэмжигдсэн учраас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний хүрээний мэдэгдэл 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэдэг саналын томъёоллоор дахин санал хураалт явуулъя.

Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү? 11 юм уу? Хэд байна тоолоорой. Айн 12 болчихож. Тоолчих яришг 21-ээс 12 дэмжигдсэн байна. Тэгэхдээ ер нь ажлын хэсэг дээр манай Засгийн газрынхан анхаараад энэн дээр нэг хандсан нэгдсэн шийдэл гаргахгүй бол төсвийн хүрээний мэдэгдэл дээр бас гишүүд сануулга өгөөд байна шүү.

3 дахь санал хураалт.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2025, 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү?

21-ээс 13 дэмжигдсэн байна. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл дагаж өргөн мэдүүлсэн хуулиудыг хэлэлцэж санал хураалт явуулж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаан дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн туршлагатайгаараа Дамдинням танилцуулчих уу? Дамдинням гишүүн танилцуулна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025, 2026 онд Төсвийн төлөөллийн тухай хуульд өөрчлөх тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Хоёр дахь асуудалдаа орно доо. Баярлалаа.

Ажлын хэсгийнхэн гарч болно. Баярлалаа.

Хоёр дахь асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл.

16.29 цагт

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай асуудлыг авч хэлэлцье ээ.

Би уничих уу. Зарлагын хяналтын дэд хороог сөрөг хүчин цөөнх одоо даргаа цөөнхийн бүлгээс Төсвийн зарлагын хяналтын дэд дарга томилогдох ёстой Монгол Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь заалтын дагуу Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс шууд явж байгаа шүү. Бүлгээс Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатарын нэрийг дэвшүүлсэн байна аа.

Намтрыг нь би товч танилцуулчихъя. Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар нь 1993-2003 онд Баянхонгор аймгийн 2 дугаар дунд сургууль, 2003-2007 онд СЭЗДС-ийг тус тус төгссөн. Санхүүч мэргэжилтэй. 2007-2015 онд Голомт банканд эдийн засаг салбарын захирал, 2016-2020 онд МУХБ-нд хэлтсийн захирал, 2021, 2023 онд Хаан банканд салбарын удирдлагын газрын захирал, 2024 онд Хадгаламж даатгалын корпорацийн газрын захирлаар тус тус ажиллаж байсан байна аа.

Нэр дэвшигчдийн талаар саналтай гишүүн байна уу? Кнопоо дар. Хөгжлийн банкны хэрэгт нэг их холбогдоогүй байлгүй дээ. Болормаа гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Бид нар чинь одоо ингээд АН-ын хүнийг Төсвийн зарлагын хорооны хяналтын хорооны даргаар цөөнхийн эсвэл сөрөг хүчний төлөөлөл гээд томилох гээд байдаг. Эвслийн Засгийн газар байгуулагдаад нэг хөнжилдөө орцгоочихсон байдаг. Тооцох юм уу? Тооцохгүй байлгүй дээ? Тэгээд би бол одоо бараг үнэхээр тэрэн дээрээ тулаад байгаа бол энэ засагт орж

ирээгүй байгаа хүмүүсээсээ оруулж ирэх ёстой юм уу? Эсвэл бүүр ингээд Ардын нам, Ардчилсан нам хамаагүй дундаасаа санал хураагаад явах ёстой юм биш үү? Асуулт байна. Ийм асуулт байна.

Ц.Даваасүрэн: Яах вэ цөөнхийн бүлэг гээд тэгэх юм одоо жишээлбэл нөгөө цөөнх байгаа шүү дээ. Нөгөө цөөнхийн бүлэг гэсэн учраас нөгөөдүүл нь бүлэггүй байхгүй юу. Зүгээр цөөнх гээд тэгэх юм бол одоо нөгөөдүүл нэр дэвшиж өрсөлдөж болно шүү дээ. Ер нь нээлттэй.

Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя, саналаа хэлье.

Д.Пүрэвдаваа: Хурал даргалагчаас нэг юм тодруулъя аа. Яг энэ хуульд ч байдаг юм уу, яг энэ цөөнхөөс гэж байгаа юм уу сөрөг хүчнээс гэж байгаа юм уу? Энийгээ яг тодорхой томъёолмоор байна. Тэгээд энэ гэрээнийхээ нөхцөлийг бас ярих ёстой байх энэ 3 намын. Тэгээд зарлагын гэдэг чинь хяналт тавих гэж байгаа биз дээ? Тэрнээс хүндээ бол надад асуудал алга. Хамгийн чухал асуудал нь үнэхээр одоо бид нар Үндэсний эвслээс сонгогдсон миний биеийн хувиар бол одоо сөрөг хүчин гэж яг хэнийг тодорхойлоод байна гэдгийг одоо бараг хуульчлах ёстой болчих гээд байна шүү дээ. Та нэг хариулт өгнө үү?

Ц.Даваасүрэн: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр энэ Улсын Их Хурлын тухай хуулийн 27.10 дээр тодорхой заачихсан юм байна. Цөөнхийн бүлгийн гишүүнээс хэрвээ цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэлцэхгүй бол цөөнхийн гишүүнээс тэгэхээр хүрэлцээд цөөнх бүлгээ байгуулчихсан байгаа байхгүй юу Ардчилсан нам.

Тийм учраас нөгөө нэг цөөнхийн бүлэг гэдгээрээ Ардчилсан нам болчихоод байгаа байхгүй юу. Намын бүлэг гэхихсэн байгаа учраас болохгүй байна.

Батболд гишүүн.

Р.Батболд: Манайх бас яг адилхан. Иргэний Зориг Ногоон Нам. Манайх бас бүлэг байхгүй. Тэгэхээр бүлэг байгуулах боломж нь олддоггүй. Тэгээд ингээд дөрвүүлээ сууж байдаг. Тэгээд цөөнхийн бүлгээсээ ингээд нэр дэвшигч байх ёстой гээд байдаг. Тэгэхээр бүлэг байхгүй. Ардчилсан нам чинь хэчнээн цөөнх болсон ч гэсэн одоо Засгаа нийлээд барьж байгаа энэ 118-ын бүлэг чинь одоо нэгдсэн 1 л бүлэг шүү дээ. Ер нь энэ дотор тийм нэг их бид нар цөөнхийн бүлэг, бид нар, олонхын бүлэг гэж яриад байх юм ерөөсөө байхгүй шүү дээ. Одоо энэ дотор чинь цөөнх гэж ярих юм бол одоо эс үгүй бол сөрөг хүчин гэж ярих юм уу. Энэ манай Иргэний Зориг ногоон нам, Үндэсний эвсэл 2 л байна шүү дээ. Бид 2 одоо нэг, нэг төлөөлөл энд сууж байна. Тэгэхээр одоо гол нь сөрөг хүчнээс нэрээ дэвшүүлээд явмаар байна. Тэгж болж байна. Тэгвэл арай гоё харагдлаа. Харагдах өнцгийн хувьд уу?

Ц.Даваасүрэн: Энэ бүлэгтэй байгаа учраас нөгөө Ардчилсан нам одоо бүлэгтэй гэдгээрээ цөөнхийн төлөөллийн нэр дэвшүүлээд байгаа байхгүй юу. Хэрвээ бүлгийн хэмжээнд гишүүдийн тоонд хүрэлцэхгүй байсан бол чөлөөтэй өрсөлдөж болохоор байгаа байхгүй юу. Даанч одоо болохгүй. Би хууль зөрчиж болохгүй болчихоод байна.

Болормаа гишүүн.

Х.Болормаа: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе ээ.

Тэгэхээр Байнгын хорооны дарга та бол угаасаа нэр заагаад Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг оруулж ирж байх шиг байна. Тэгэхээр би өөр одоо бас гишүүнийг санал болгох саналтай байгаад байгаа юм.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр өрсөлдөж болохгүй юм байна. Яг энэ хууль дээрээ тодорхой.

Би та нарт дахиад уншаад өгье юу. Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхын саналаар сонгоно гэж байгаа юм. Одоо бид нар сонгох гэж байна. Төсвийн зарлагын хяналтын хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс гэж байгаа байхгүй юу. Хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгоно гэж байгаа юм.

Тэгэхээр цөөнхийн бүлгийн гишүүдээс сонгох болчихож байгаа юм. Цөөнхийн бүлгийн гишүүдээс энийгээ дэвшүүлээч гээд АН-ын бүлгээс нэр ирүүлчихсэн. Тэгэхээр энэ ирсэн нэр болохоор Цогтгэрэл даргын ирүүлсэн нэрийг би та бүхэнд уншиж танилцуулж байгаа байхгүй юу.

Тэгэхээр та нар уг нь бүлэг дотроо бол чөлөөтэй өрсөлдөж болно. Болсон уу? Одоо нөгөө гар өргөхөөрөө л явж байгаа шүү дээ бид нар чинь, тийм.

Энэ дээр тийм юм байна уу? Илээр болохгүй гэж байна уу? Үгүй байх. Үгүй байх энэ чинь тийм биш. Өөр юун дээр хийдэг юм.

Манай хуулийнхан байна уу? Хэрвээ байна шүү дээ зүгээр ийм л юм байгаа гишүүд ээ. Ийм л асуудал байж болох юм байна. Яах вэ одоо ингээд АН-ын бүлгийн гишүүдээс нөгөө бүлгээс санал ирчихдэг юм. Тэгэхдээ бүлгийн гишүүдээ сонгож болохоор байгаа байхгүй юу. Уг нь яах вэ АН-ын бүлгээс одоо хэн нэг нь би өрсөлдөнө гэвэл бас нээлттэй л юм шиг байна л даа. Тэгвэл одоо нэр дэвших хүн байхгүй байгаа нь гэж ойлголоо. Бүлэг гэж хязгаарлачихсан байгаа учраас арга байхгүй. Зөвхөн АН-ын бүлгээс дэвшихээр байгаа байхгүй юу. Гишүүдээ одоо та бүгд ингэж болно.

Ингээд нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүн байна уу? Тэрэнд ороод яачих кнопоо дараарай. Нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүн байна уу? Батбаяр гишүүн байна уу? Хөөе

Батбаяр. Нөгөө тэрэн дээр гарчихсан учраас яаж ч чадахгүй болчихгүй юу би. Батболд гишүүн асуултаа асууя.

Одоо уг хэлж болно шүү.

Р.Батболд: Зардлын хяналтын дэд хорооны даргад өрсөлдөх боломжгүй. Ямар ч байсан бүлгээр хязгаарлагдаад ингэчихлээ. Зүгээр эндээс тэгвэл яаралтай горимоор дахиад энэ хуульд өөрчлөлт, дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах юм уу ийм санал гаргаж болох уу? Тийм Их Хурлын тухай хууль дээр. Тэгэхгүй бол энэ чинь бас их л сонин асуудал болоод байна л даа. Бид нар чинь одоо ингээд ямар ч асуудал дээр орсон ингээд та нар бүлэг байхгүй шүү дээ гээд ингээд 8 гишүүн ямар ч ажилгүй байх нь байна шүү дээ. Ер нь одоо ингээд хараад байхад бүлэгт ороод ч хэрэг алга, байхгүй байгаад ч хэрэг алга. Тэгээд одоо юу хийгээд сууж сууж байх юм энд чинь. Одоо тийм л ажил болоод байна. Тэгэхээр энийг тийм хуульд өөрчлөлт оруулах санал гаргаж болох уу?

Ц.Даваасүрэн: Батболд гишүүн ээ энэ одоо бид нарын явж байгаа чуулган бол ээлжит бус. Ээлжит бус чуулганаар зөвхөн товлосон асуудал хэлэлцэнэ. Тийм учраас энэ удаа бол хэлэлцэх боломжгүй. Яах вэ тэгвэл одоо энэ дэд даргын асуудлыг бас хойшлуулаад орхичихъё л доо. Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах эрх нь гишүүний хувьд танд нээлттэй байгаа. Тийм байна. Тийм учраас та хууль санаачилж болно. Ингээд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн алга байна.

Санал хураалт явуулна.

Үгүй нууцаар гэж юм байхгүй юм байна шүү дээ. Илээр болох юм байна. Нөгөө гар өргөдгөөрөө л явуулчихъя хэдүүлээ. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаар АН-ын бүлгийн саналын дагуу УИХ-ын гишүүн Даваагийн Цогтбаатарыг сонгох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд ээ анхаараарай хөөе уначих гээд байна шүү. 21-ээс тооцно шүү.

12 дэмжигдсэн байна. Энэ чинь ахиад баталъя гэж бас явах юм уу? Бас тогтоол уншина гэнэ. Тэгээд тогтоолоо батлах юм байна.

Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол

16.47 цагт

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*